БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ДЭЛХИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗӨВЛӨЛӨӨС САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ

# “ШИНЭ ХЭВИЙН БАЙДАЛ”-Д МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЯЛЛЫН ОЛОН УЛСЫН УДИРДАМЖ & ШОШГО



Safe travels by WORLD TRAVEL & TOURISM COUNCIL





# АЮУЛГҮЙ АЯЛЛЫН ОЛОН УЛСЫН УДИРДАМЖ & ШОШГО

## АЮУЛГҮЙ АЯЛЛЫН ПРОТОКОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

- Ковид19 цар тахлын дараа аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг дахин эхлүүлэх, хурдан сэргээхэд чиглэсэн аюулгүй аяллын удирдамжийг Дэлхийн аялал жуулчлалын зөвлөл (ДАЖЗ)-өөс шинээр боловсруулжээ.
- Олон улсын энэхүү удирдамж нь аялагч, жуулчдын болон салбарын итгэлийг сэргээх, хязгаарлалтыг бууруулсны дараа аюулгүй аяллыг дахин эхлүүлэхэд туслах зорилготой юм. Эдгээр удирдамж нь зорин очих улсын эрх бүхий байгууллагуудыг нэгдсэн удирдамжаар хангахын зэрэгцээ COVID-19-ийн дараах дэлхийн эрүүл мэнд, эрүүл ахуйн шинэ хандлагын талаар аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч, тур оператор, аялагчдад зориулсан зааварчилгаа болно.
- Олон улсын удирдамжийг ДАЖЗ-ийн гишүүд, салбарын тэргүүлэгч холбоод, олон улсын байгууллагуудтай хамтран боловсруулсан. Эдгээр баримт бичигт Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) болон Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төв (ӨХУС)-ийн хамгийн сүүлийн зөвлөмж, зааварчилгааг эмхэтгэж боловсруулсан болно.
- Удирдамжууд нь COVID-19-ийн талаар шинэ мэдээлэл гарах бүрд шинэчлэгдэж байх "амьд" баримт бичиг юм. Тиймээс ДАЖЗ нь хувийн хэвшил, зорин очих улсын эрх баригчдад эрсдэлд суурилсан хандлагыг хэрэгжүүлж, эрсдлийн аливаа нөхцөл байдалтай арга хэмжээг нийцүүлэхийг зөвлөж байна. Учир нь бүх зүйлд нэг хэмжээстэй байх нь шийдэл биш юм.
- Аюулгүй аяллын удирдамж нь аялал жуулчлалын гол салбар тус бүрд зориулагдсан. Улмаар COVID-19-ын дараа аялал жуулчлалын салбар сэргэхийн хэрээр аялагч, ажиллах хүчний аюулгүй байдалд чиглэсэн уялдаа холбоо, тогтвортой байдлыг хангахад тусална. Тиймээс ч салбарын удирдамжуудыг үе шаттайгаар боловсруулж, нэвтрүүлж байна. Одоогийн байдлаар зочлох үйлчилгээ, жижиглэнгийн худалдаа, агаарын тээвэр, нисэх онгоцны буудал, тур оператор, уулзалт, арга хэмжээ зохион байгуулах гэсэн зургаан салбарын удирдамжийг бэлэн болгосон байна. Богино хугацааны түрээсийн салбар, аялал жуулчлалын үзмэр, үйлчилгээ, даатгал, автомашины түрээс, далайн аяллын удирдамжийг боловсруулж байна.
- Аюулгүй аяллын удирдамж тус бүр нь дөрвөн бүлгээс бүрдэнэ. Үүнд: 1. Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдал, 2. Аюулгүй үйлчилгээ үзүүлэх, 3. Аялагчдын итгэлийг сэргээх, 4. Бодлогын түвшинд дэмжлэг авах.
- Аюулгүй аяллын удирдамж хэрэгжүүлэхийг үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн удирдлагуудад ДАЖЗ-өөс уриалж байна. Ингэснээр эдгээр удирдамжийг дэлхийн хэмжээнд хэрэгжүүлж, аялал жуулчлалын салбарыг дахин эхлүүлэхэд аялагч, жуулчдад нэн шаардлагатай байгаа итгэлийг сэргээж чадна.

## АЮУЛГҮЙ АЯЛЛЫН ТЭМДЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

- Аюулгүй аяллын тэмдэг бол Ковид19 цар тахлын халдвартай тэмцэх зорилгоор тусгайлан бий болгосон дэлхийн аялал жуулчлалын салбарын анхны аюулгүй байдал, эрүүл ахуйн тэмдэг юм.
- Энэхүү тэмдэг нь дэлхийн өнцөг булан бүрийн зорин очих улсын эрх баригчид, компаниуд эрүүл мэнд, эрүүл ахуйн удирдамжийг ДАЖЗ-ийн аюулгүй аяллын удирдамжуудтай нийцүүлэн хэрэгжүүлсэн болохыг аялагчид болон бусад аялал жуулчлалын сонирхогч талуудад таних боломжийг олгоно.
- Бүх улс орнууд, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд, зорин очих улсын эрх бүхий байгууллагууд Аюулгүй аяллын удирдамжуудыг, агаарын тээврийн салбарт Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-ын “Нислэг: Ковид19 нийгмийн эрүүл мэндийн хямралын үеийн агаарын аяллын удирдамж”-ийг мөрдсөн тохиолдолд энэхүү тэмдгийг ашиглах боломжтой бөгөөд гэрээний нөхцөлд гарын үсэг зурна.
- Агаарын тээврийн салбарт ДАЖЗ-ийн Аюулгүй аяллын тэмдэг нь Аюулгүй аяллын удирдамж, ОУИНБ-ын нислэгийн удирдамжийг баталсан улс, чиглэлд танигдах, ашиглах боломжтой.
- Тэмдгийг үнэ төлбөргүй хэрэглэнэ.
- Аюулгүй аяллын тэмдэг нь өөрийн үнэлгээнд үндэслэгдэх бөгөөд баталгаажуулалт биш юм. Энэхүү тэмдгийг ашиглаж буй улс орнууд, зорин очих улсын эрх баригчид, компаниуд Аюулгүй аяллын протокол болон ОУИНБ-ын нислэгийн удирдамжийг хэрэгжүүлж, байнга дагаж мөрдөж байгаагаа нотолсон байна.

## ДЭЛХИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА



# ТАНИЛЦУУЛГА

## АЛСЫН ХАРАА

Цар тахлын дараах аялал жуулчлалын салбарыг нэн даруй сэргээхэд, Ковид19-н нөлөөллийг бууруулахад талууд хамтарч Засгийн газар, эрүүл мэндийн байгууллагуудтай нягт, уялдаатай ажиллах нь нэн чухал болоод байна.

## ЗОРИЛГО

Дэлхийн аялал жуулчлалын зөвлөл нь салбарыг оновчтой сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, төрийн болон хувийн хэвшлийн харилцан ойлголцол, хэрэгжилтийг хангах арга хэрэгслийг тодорхойлох замаар салбарыг үр дүнтэй сэргээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажиллаж байна. Энэ зорилгоор ДАЖЗ нь Засгийн газар, эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүд, хувийн хэвшил, аялагчдын цаашдын хүсэл шаардлагыг авч үзэх ба хүмүүс өөрсдийгөө аюулгүй гэж үздэг болох хамтарсан шийдэл, удирдамж боловсруулахад хамтран ажиллана.

**Нийтлэг дүрэм журамтай байх нь хамгийн чухал юм.**

ДАЖЗ нь ирээдүйд аюулгүй, найдвартай, саадгүй, аяллын туршид аялагчдад бодит туршлагыг бий болгох, сая сая хүний амьжиргааг дэмжиж, эдийн засгийн тогтвортой өсөлтөд хувь нэмэр оруулах  аялал жуулчлалыг төсөөлж байна.

## “ШИНЭ ХЭВИЙН БАЙДАЛ”-Д МӨРДӨХ ОЛОН УЛСЫН УДИРДАМЖ

Салбарыг сэргээх санаачлагын хүрээнд ДАЖЗ нь үйл ажиллагааны болон эрүүл мэндийн шинэ удирдамж боловсруулахдаа өөрийн гишүүд, Засгийн газар, эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

Тодруулбал, ДАЖЗ нь аялал жуулчлалын найман салбарт удирдамжийн товч баримт бичгийг бий болгоно. Ингэснээр хувийн хэвшил нийтлэг нэг стандарттай болж, салбар хэвийн хэмжээнд шилжих нөхцлийг бүрдүүлэх юм.

Аялал жуулчлалын чиглэлээр санал болгож буй салбар:

- Зочлох үйлчилгээ
- Жижиглэн худалдаа
- Агаарын тээвэр
- Нисэх буудал

- Далайн аялал
- Тур оператор
- Хурал, цуглаан, арга хэмжээ
- Машины түрээс
- Даатгал
- Богино хугацааны түрээс

Энэхүү ажил нь аялал жуулчлалын салбарын олон улсын байгууллага, салбарын холбоод болон манай гишүүдийн хамтын ажиллагааны хүчин чармайлтад тулгуурлана.

ДАЖЗ нь Засгийн газар, эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахын зэрэгцээ хувийн хэвшлийн хэрэгцээг төрийн бодлогод авч үзэж, тусгуулахад анхаарч ажиллах болно.



# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ҮНДСЭН ЗОРИЛТ БОЛОН АРГАЧЛАЛ

## ЗОРИЛТ

1. Аялал жуулчлалын салбар хямралын үеийн удирдлагаас сэргэлтийн үе рүү шилжихэд тохирсон шилдэг хандлага, удирдамжийг салбарын зүгээс тодорхойлох.
2. Олон улсын удирдамжийг боловсруулахдаа аялагчдын болон аялал жуулчлалын салбарын ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийг чухалчлан үзэх.

## АРГАЧЛАЛ

1. Аялал жуулчлалын салбар, Засгийн газар, нийгмийн эрүүл мэндийн байгууллагууд ил тод зарчмаар уялдаа холбоотой ажиллах, аливаа асуудалд тооцоо судалгаатай хандах.
2. Улс орнууд болон зорин очих газарт энгийн, амьдралд хэрэгжихээр, үр дүнд тулгуурласан удирдамж боловсруулан хэрэгжүүлэх.
3. Үр дүнтэй харилцаа холбоо болон маркетингаар дамжуулан аялагчдын итгэлийг сэргээх, шинээр хэрэгжүүлж буй удирдамж нь тэднийг аюулгүй байлгах бүхий л боломжоог хангасан гэдгийг мэдэгдэх.
4. Салбарыг буцаан сэргээх, эрэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн урамшууллын бодлого хэрэгжүүлэх.



# ШОШГО ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

1. Цар тахлын халдвараас урдчилан сэргийлэх арга хэмжээ /хяналтын хуудас, тусгай ариутгал, цэвэрлэгээ г.м зүйлсийг багтаасан/-ний цогц төлөвлөгөө боловсруулсан байх;
2. Эрсдлийн үнэлгээ хийх журам боловсруулж, хэрэгжүүлэх;
3. Эрчимжүүлсэн ариун цэвэр, ариутгал, халдваргүйтгэл, гүн цэвэрлэгээний арга хэмжээг өндөр давтамжтай хийхэд чиглэсэн дүрэм, журам боловсруулж, батлах;
4. Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах дүрэм, журам боловсруулах;
5. Шинэ нөхцөл байдалд үйл ажиллагаагаа хэвийн явуулах төлөвлөгөө боловсруулж, баталсан байх;
6. Ажилтнуудын давтан сургалтыг зохион байгуулсан байх;
7. Дээрх арга хэмжээний хэрэгжилтийг нотлох баримт/бүртгэл хөтөлдөг байх;
8. Ажилтны ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулах;
9. Аялагчдын ёс зүйн дүрэм боловсруулсан байх;
10. Цар тахлын халдвар авсан эсвэл сэжигтэй тохиолдол илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, ажилтанг бэлтгэсэн байх;
11. Оролцогч бүх талуудад ижил төстэй журам хэрэгжүүлэх талаар тохиролцож, хэрэгжилтийг хангасан байх.






# ТУР ОПЕРАТОР

WORLD TRAVEL & TOURISM COUNCIL

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ



# ТАНИЛЦУУЛГА

Аялал жуулчлалын салбар эргэн сэргэхэд салбарын бүх байгууллагууд тодорхой, амьдрал дээр хэрэгжихүйц хөтөлбөр боловсруулсан байх нь чухал. Тэр дундаа тур операторын хувьд энэ нь нэн чухал юм. Учир нь тур операторын үйл ажиллагаа нь зорин очих газар, авиа компаниуд, зочид буудал, тээврийн компаниуд, аяллын даатгал, мөн тухайн улсын хууль тогтоомж (хөл хорио, хил хаах г.м) зэрэг зүйлсээс хамааралтай байдаг.

Тур операторуудад зориулсан дараах удирдамжийг дэлхийн тэргүүлэх тур операторуудын зөвлөмж болон тэдгээрийн олон нийтэд нээлттэй тавьсан аялал жуулчлалын үйл ажиллагааг эрүүл, хариуцлагатай буцаан үргэлжлүүлэх төлөвлөгөөнөөс нэгтгэн боловсруулсан юм. Мөн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ), АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төв (ӨХТ), Европын Өвчний хяналт, сэргийлэлтийн төв (ЕӨХТ) зэрэг байгууллагын зөвлөмж, зааварчилгааг уялдуулан тус практик удирдамжийг боловсруулсан билээ. Үүний гол зорилго нь аялагчдын аюулгүй аялахад шаардлагатай биеэр хүрэх нөхцлийг багасгасан, эрүүл мэнд, эрүүл ахуйн асуудалд илүү төвлөрсөн холбогдох бүх чиг үүргийн практик удирдамжийг бий болгоход оршино. Вирусийн талаарх мэдээлэл нэмэгдэхийн хирээр эдгээр практик удирдамжууд нь өөрчлөгдөх, цаашид улам сайжрах юм.

Тур оператор бүр өөрийн гэсэн онцлог нөхцөл байдалтай тул эдгээр удирдамжийг хэрэгжүүлэхийн өмнө тур операторуудтай зөвлөлдөх шаардлагатай. Мөн тухайн тур операторууд үндэсний болон орон нутгийн хууль, тогтоомжийн шаардлага болон ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг дагаж мөрдөх нь зүйтэй.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй бүхий л этгээдэд илүү хялбар болгохын тулд удирдамжийг дараах 4 бүлэгт хуваасан. Үүнд:

1. **Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Аялагчдын итгэлийг сэргээх**
4. **Урамшууллын бодлого хэрэгжүүлэх**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЖИЛТНУУДЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

**Тур операторууд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Юуны түрүүнд зочлох үйлчилгээний салбар, байгууллагууд шинэ нөхцөл байдалд үйл ажиллагаагаа хэвийн явуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажилтнуудаа бэлтгэсэн байх шаардлагатай.**

- Дараах нөхцлийг бүрдүүлсэн Тур операторын үйл ажиллагааг дахин эхлүүлэх боломжтой. Үүнд:
  - Засгийн газраас үйл ажиллагаагаа явуулах, дахин сэргээхэд шаардагдах бүх зөвшөөрөл, лиценз авсан байх;
  - Ковид19 цар тахлын халдвараас урдчилан сэргийлэх арга хэмжээ /хяналтын хуудас, тусгай ариутгал, цэвэрлэгээ г.м зүйлсийг багтаасан/-ний цогц төлөвлөгөө боловсруулах;
  - Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийг боловсруулах, үүнд, үндэсний хэмжээнд мөрдөж буй хууль, тогтоомжийн шаардлагын дагуу ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах заалт оруулах, хэрэв ийм шаардлага байхгүй бол нисэх буудлаас Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу шинж тэмдэгтэй эсвэл өндөр температуртай ажилтныг гэртээ байх журам боловсруулж, мэдээлэх;
  - Оффист хүн хоорондын зайг баримталсан зохион байгуулалтыг шинээр хийх, амрах өрөөнүүдэд нэг дор байх ажилтнуудын тоог хязгаарлах, холбогдох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг  мөрдөх;
  - Биеэр хүрэх нөхцлийг багасгах, үүнтэй холбоотой дотоодын хууль тогтоомжийг мөрдөх;
  - Үндэсний хууль тогтоомжийн шаардлагын дагуу эрсдлийн үнэлгээнд үндэслэн шаардлагатай бол нүүрний хаалт, маск зэрэг шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ)-ээр ажилтныг хангах;
  - Боломжтой бол автоматжуулсан, зайнаас төлбөр төлөх технологийг  нэвтрүүлж биеэр хүрэх нөхцлийг багасгах. Хэрэв боломжгүй бол гар ариутгагч болон бээлийгээр хангах;
  - Хамтран нийлүүлэгчид болон ресторан, зочид буудал, цэцэрлэгт хүрээлэн, тээврийн компани, хурал, цуглаан, арга хэмжээ зохион байгуулдаг газар зэрэг хамтрагч байгууллагууд аялагчдын эрүүл мэндийг хамгаалах ижил төстэй арга хэмжээнүүдийг авах талаар харилцан тохирох; Дэлхийн аялал жуулчлалын зөвлөлийн Зочлох үйлчилгээ, Агаарын тээвэр ба Нисэх буудалд зориулсан удирдамжийг харна уу.
  - Шинэ халдвар илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний Ковид19 цар тахлын гэнэтийн тохиолдлын төлөвлөгөөг хангаан нийлүүлэгч болон хамтран ажилладаг байгууллагуудтай хамтран боловсруулах;
  - Мэргэжлийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага, Засгийн газрын байгууллагаас баталгаажуулж, баталсан ариутгал, халдваргүйтгэлийн зохистой шилдэг туршлага, дадлыг хэвшүүлсэн байх;
  - Цагийн хуваарьтай оруулах, урьдчилан тасалбар захих, групп аялагчдын тоог багасгах зэрэг боломжуудыг судалсан байх.

- Тур операторууд үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд ажилтнуудаа дараах байдлаар сургаж, бэлтгэсэн байна. Үүнд:
    - Хөтөч, жолооч, орон нутгийн мэргэжилтэнг багтаасан ажилтнуудад зориулсан дотоод журам, зааварчилгаа болон асуулт хариулт бүхий заавар боловсруулж, хэрэгжүүлсэн байх;
    - Ажилтнуудаа халдвараас сэргийлэх, биеэр хүрэлцэх, хоол хүнс, сав суулга дундаа хэрэглэх, зохих хувцас хэрэглэл ашиглах, мөн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын зөвлөсний дагуу эрүүл ахуйн сайжруулсан арга хэмжээ авах, маск, бээлий хэрэглэх талаар шаардлагатай мэдээлэл, хэрэгслээр хангасан байх; компанийн дотоод журмаар илүү нарийн шаардлага тогтоож болно;
    - Салбарын хэмжээнд нэгдмэл, уялдаатай арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор хамтран ажилдаг хурал, цуглаан, арга хэмжээ зохион байгуулдаг газар, зочид буудал, тээврийн компани зэрэг байгууллагад ижил төстэй арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тохирох;
    - Бүх сургалт нь ДЭМБ зэрэг олон улсын эрүүл мэндийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх.
    - Ажилтнуудын эрүүл мэндэд байнгын анхаарал хяналт тавьж, тэднийг Засгийн газар болон ДЭМБ-ын заавар зөвлөмжийг даган мөрдөхөд нь урамшуулан, манлайлж ажиллах.

# 2.ХАРИУЦЛАГТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

**Өндөржүүлсэн ариун цэвэр, халдваргүйтгэл дээр тулгуурласан ажилтнууд болон аялагчдад аюулгүй үйл ажиллагаа явуулахын тулд тур операторууд дараах нөхцлийг бүрдүүлсэн байна. Үүнд:**

- Өөрсдийн хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хանган нийлүүлэгчдэд танилцуулан ойлгуулсан байх;

- Өндөржүүлсэн ариун цэвэр, халдваргүйтгэлийн арга хэмжээг ханган нийлүүлэгчдийн бараа бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэлд тодорхой давтамжтайгаар хийхээр тохиролцсон байх:
    - Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
    - Гар болон биеэр хамгийн их хүрдэг хэсгүүд болох шатны бариул, хаалганы бариул, ширээ, ариун цэврийн өрөөний суултуур, агааржуулалтын шүүлтүүр, дээд тавиур, суудлын толгойн түшлэг зэрэг газруудыг цэвэрлэх аргачлалыг шинэчлэх, давтамжийг нэмэгдүүлэх;
    - Аялагч, жуулчдад зориулан хэрэглэхийг зөвшөөрсөн спиртэн суурьтай гар ариутгагчийг бэлэн байлгах. Ариутгалын нэмэлт бүтээгдэхүүнийг өгөх эсвэл худалдан авах боломжтой болгох;
    - Нэг суудалд байнга суух хуваарь хийх, үндэсний хууль тогтоомжийн шаардлагын дагуу суудал хоорондын зай барих;
    - Хуванцар уутаар доторлосон хогийн сав бэлэн байлгаж хогийн уутыг тогтмол солих;
    - Тээврийн компаниудтай ариун цэвэр, халдваргүйтгэлийн асуудлаар ижил төстэй арга хэмжээ авч буй талаар ярилцаж тохиролцсон байх.

- Үйлчлүүлэгчид чиглэн зочдын мэдээлэл, хүн хоорондын зай барих шаардлага зэрэг мэдээллийг багтаасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх:
    - Хууль тогтоомжид заасны дагуу зочдын эрүүл мэндийн хяналтыг хэрэгжүүлэх;
    - Биеэр хүрэлцэх, дугаарлаж зогсох зэрэг нөхцлийг хязгаарласан байх;
    - Хууль тогтоомжид заасны дагуу шаардлагатай бол маск хэрэглэхийг зөвлөх;
    - Бүртгэх, төлбөр төлөх нөхцлүүдийг боломжтой бол цахимжуулах;
    - Боломжтой бол хурал, цуглаан, арга хэмжээ зохион байгуулдаг газар, зочид буудал, ресторан зэрэг газруудад зочдыг оруулахдаа цагийн зөрүүтэй хуваарилалт хийх.
- Дэлгүүр хоршоо, хурлын танхим, амталгааны газар, музей, шоу театр, концертын танхим, үйлдвэр, фермийн аж ахуй гэх мэт хамтран ажилладаг байгууллага болон ханган нийлүүлэгчтэй эрүүл ахуй, халдваргүйтгэлийн ижил төстэй арга хэмжээ хэрэгжүүлэх талаар харилцан тохиролцох.
- Хамтран ажилладаг ресторан халдваргүйтгэлийн дараах ижил төстэй арга хэмжээ хэрэгжүүлэх талаар харилцан тохиролцсон байх:
    - Үйлчлүүлэгчид зориулан хэрэглэхийг зөвшөөрсөн спиртэн суурьтай гар ариутгагчийг рестораны орох хэсэгт бэлэн байлгах;
    - Ресторан нь ажилтнуддаа мөн эдгээр ариун цэвэр, халдваргүйтгэлийн дүрэм журмыг сургаж, дагаж мөрдөх асуудлаар тохирсон байх;
    - Буфетийн хэсэгт зочдыг өөрсдөөр нь хүнсэнд хүргүүлэхгүй байх;
    - Цай, кофены машиныг тогтмол цэвэрлэх, боломжтой бол үйлчлэгч ажиллуулах;
    - Зочдыг гармагц ширээг ариутгалын шаардлагын дагуу нэн даруй цэвэрлэх, боломжтой бол аяга таваг угаагч машин ашиглаж аль болох гараар угаахгүй байх;
    - Үндэсний хууль тогтоомжийн дагуу ширээ, зочдын суудал хоорондын зай барих шаардлагыг баримтлах;



- Зочдын ширээн дээр тавих эд зүйлсийн тоог багасгаж, боломжтой бол багцалж, ариутгасан хэрэгсэл ашиглах;
- Төлбөр хийх аргыг шинэчилж, контактгүй, урьдчилсан төлбөрийн шийдлийг нэвтрүүлэх;
- Ажиллах цагийг уртасган зочдыг нэг дор хүлээн авах ачааллыг багасгах арга хэмжээ авах.

# 3.АЯЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ СЭРГЭЭХ

**Тур операторууд үйлчилгээний ил тод байдал, найрсаг харилцаанд тулгуурлан аялагчдын итгэлийг сэргээхийн тулд дараах зүйлс дээр анхаарна. Үүнд:**

- Байгууллагын дижитал болон шууд сувгийг ашиглан эрүүл мэнд/эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод байдлаар тогтмол хүргэх. Цэвэрлэгээний компаниудтай хамтран ажиллаж, зайнаас харьцах, сайжруулсан цэвэрлэгээний журмын талаар зочдод мэдээлэх тодорхой тэмдгүүдийг тавих;
- Аялалд бүртгэж байх үед эсвэл аялал эхлэхийн өмнө эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу нүүр, амны хаалт, гарын ариун цэвэр болон зайнаас харьцах асуудлаар зааварчилгааг зочид нэг бүрт өгөх. Эдгээр зааварчилгааг бүрэн ойлгосон эсэхийг зочдоор баталгаажуулах;
- Асуулт, асуудал байвал дэмжлэг авах боломжтой болохыг зочдод мэдэгдэх.
- Зочидтой эхний эгнээнд ажиллаж буй ажилтнуудыг асуултанд хариулах, шинэ тохиолдол илрэх гэх мэт бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, зочид дүрмээ дагаж мөрдөхгүй байгаа нөхцөл байдалд анхаарах, аялагчдыг тайвшруулахын тулд аяллын өмнө болон үеэр удирдамжийг дахин таницуулах зэрэгт бэлтгэсэн байх;
- Эрүүл мэндийн болон аяллын даатгалын компаниудтай хамтран ажиллах боломжийг судлах, яаралтай нутаг буцаах, эмнэлгийн тусламж гэх мэт шаардлагатай тохиолдолд ашиглах Ковид19-ийн аяллын даатгалын хамрах хүрээг санал болгох;
- Үндэсний хууль тогтоомжийн хүрээнд зөвшөөрсөн бол хавьтлыг мөшгөх аппликейшн ашиглах.

# 4.УРАМШУУЛЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Тур операторууд эргэж сэргэхэд Засгийн газрын дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Иймээс тур операторууд Засгийн газарт дараах хүсэлт тавих хэрэгтэй:**

- Хил дамнасан аяллын шинэ дүрэм боловсруулахдаа салбарын байгууллага болон бусад Засгийн газруудтай хамтран ажиллах, энэ талаар урьдчилан мэдэгдэх;
- Эрэлтийг өдөөх зорилгоор татвар, төлбөр, хураамжийг бууруулах замаар салбарт санхүүгийн туслалцаа үзүүлэх;
- Аялал жуулчлалын эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор урамшууллыг бий болгох, шууд дэмжлэг үзүүлэх;
- Дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зорин очих газрын сурталчилгааг сайжруулах;
- Аялагчдад визийн хөнгөлөлт үзүүлэх эсвэл бүр визгүй зорчих хувилбарыг судлах.




# АГААРЫН ТЭЭВЭР

WORLD TRAVEL & TOURISM COUNCIL

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ

# ТАНИЛЦУУЛГА

Дараах удирдамж нь *"Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (ICAO)"*-аас нисэхийн салбарт зориулан боловсруулсан *"Нислэг: Ковид19 Нийгмийн эрүүл мэндийн хямралын үед агаарын аяллын зааварчилгаа"* зөвлөмжид нийцсэнийг дуулгахад таатай байна. Мөн ДЭМБ зэрэг хүлээн зөвшөөрөгдсөн бусад байгууллагын зөвлөмж, зааварчилгаатай уялдуулан боловсрууллаа.

Бидний зорилго зорчигчдын хүсэн, хүлээж буй эрүүл мэнд, аюулгүй байдалд илүү анхаарал хандуулсан удирдамжийг холбогдох бүх үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байхад оршино. Дэлхийн өнцөг булан бүрт аялалыг зуучлагчийн хувьд агаарын тээврийн салбар нь аюулгүй зорчих нөхлийг хангаж, Засгийн газрын бодлогын дагуу бусад оронд аялах явцад тавигдах шаардлагыг үр дүнтэй хүргэх талаар чармайн ажиллах шаардлагатай.

Цаашид вирусийн талаарх мэдээлэл нэмэгдэхийн хэрээр эдгээр удирдамж нь өөрчлөгдөн сайжирна. Эдгээр удирдамжийг агаарын тээврийн байгууллага өөрсдийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн бүх агаарын тээврийн байгууллага хууль тогтоомж болон тухайн орон нутагт дагаж, мөрдөж буй шаардлага, ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг дагаж мөрдөх хэрэгтэй.

Тодорхойлсон арга хэмжээ нь хадварын тархалт ихтэй, өндөр эрсдэлтэй маршрут дээр үндэслэсэн болохыг тэмдэглэх нь чухал юм. Тиймээс эрсдэл багатай маршрутын хувьд эрсдлийн үнэлгээний түвшинд тохируулан өөрчлөлтүүдийг оруулахыг зөвлөж байна. Учир нь зарим аргачлал нь эрсдэлийн бага түвшинд шаардлагагүй байж болох юм. Мөн авсан арга хэмжээ, тогтоосон журмыг тогтмол хугацаанд дахин нягталж үзэх шаардлагатай. Эрсдэл буурах тусам дагаж арга хэмжээг сулруулах нь үр дүнтэй. Цаашид илүү үр дүнтэй, тохиромжтой, хэрэгжүүлэхэд хүндрэл багатай, шинжлэх ухааны үндэслэлтэй эхний боломжоор хэрэгжүүлж, өмнө авч байсан арга хэмжээг хүчингүй болгох хэрэгтэй.

Ковид19 цар тахлын дараах аялал жуулчлалын салбарын хамгийн эхний бөгөөд чухал алхам бол зорчигчдад аюулгүй гэдгийг мэдрүүлэх явдал юм. Иймд зорчигчдын аюулгүй байдалд чиглэсэн ямар арга хэмжээ, журам хэрэгжүүлж байгаа тухай энгийн, ил тод байдлаар зорчигчдад мэдээлэх хэрэгтэй.

Зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор энэхүү удирдамжийг боловсруулахдаа эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан бөгөөд дараах асуудлыг авч үзнэ. Үүнд:

1. Нисэх буудалд зорчигчийн биеийн байдал болон халууныг хэмжих системийг нэвтрүүлэх;
2. Ариун цэвэр, халдваргүйтгэлийн арга хэмжээг ялангуяа бүртгэлийн хэсэг болон онгоцонд суух хэсгүүдэд нэмэгдүүлэх;
3. Хөл, хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд зорчигчдод зориулсан ариутгагч бодис байршуулах;
4. Өнөөгийн шаардлага, дадалд нийцүүлэн бүх хүрэлцэх цэгүүдэд биеэр хүрэх нөхцлийг багасгах, хязгаарлах;
5. Хоорондын зайн ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээ, шалны наалт байрлуулах, зарлах;
6. Эрсдлийн үнэлгээгээр шаардлагатай гэж тогтоогдсон хугацаанд нисэх багийн гишүүд болон зорчигчдод амны хаалт зайлшгүй зүүх шаардлага тавих;

7. Зорчигч болон нисэх буудлын ажилтнуудын хоорондын шууд харилцааг боломжийн хэмжээгээр багасгаж, өөртөө үйлчлэх паспортын цэг, төлбөрийн аргачлалыг нэвтрүүлэх;
8. Зорчигчтой шууд, байнга харьцдаг үйлчилгээний ажилтнуудыг эрүүл мэндийн холбоотой асуултад хариулах чадвартай болгон сургаж бэлтгэх;
9. Засгийн газраас зорчигчдыг бүртгэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах арга хэмжээний стандартчилагдсан удирдамж бий болгох.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй бүхий л этгээдэд илүү хялбар болгохын тулд удирдамжийг дараах 4 бүлэгт хуваасан. Үүнд:

1. **Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Зорчигчдын итгэлийг сэргээх**
4. **Урамшууллын бодлого хэрэгжүүлэх**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЖИЛТНУУДЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

**Агаарын тээврийн салбар “шинэ хэвийн байдал”-д үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Юуны түрүүнд үйл ажиллагаагаар хэвийн явуулж, амжилттай ажиллах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажилтнуудаа бэлтгэсэн байх шаардлагатай.**

- Дараах нөхцлүүдийг хангаснаар агаарын тээврийн компаниуд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэх боломжтой:
  - Үйл ажиллагаагаа дахин сэргээхэд шаардагдах бүх зөвшөөрөл, лиценз авсан байх, хилийн хязгаарлалттай холбоотойгоор тухайн улсын Засгийн газраас багийн гишүүдэд тусгайлсан зөвшөөрөл шаардлагатай байж болохыг анхаарах; лицензийн гэрчилгээ, лицензтэй бүх ажилтнуудын зэрэглэлийг дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх шаардлагатай байна.
  - Ковид19 цар тахлын халдвараас урдчилан сэргийлэх арга хэмжээ /хяналтын хуудас, тусгай ариутгал, цэвэрлэгээ г.м зүйлсийг багтаасан/-ний цогц төлөвлөгөө боловсруулах;
  - Эрэлтэд нийцүүлэн слот хуваарилалтын уян хатан практик нэвтрүүлэх;
  - Нислэгийн батлагдсан хуваарь, түүнчлэн үйл ажиллагаа дахин эхлэхэд шаардлагатай гэрчилгээ, нисэх бүрэлдэхүүнд шаардлагатай зөвшөөрөл бэлэн байлгах;
  - Хамтарч ажилладаг нисэх онгоцны буудлууд ижил төстэй удирдамжийг боловсруулсан байх;
  - Нийтийн хоолны байгууллага гэх мэт нийлүүлэлтийн сүлжээний түншүүдтэй ижил төстэй удирдамж хэрэгжүүлэх;
  - Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийг боловсруулах. Үндэсний хэмжээнд мөрдөж буй зохицуулалтын дагуу ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах заалт оруулах,

хэрэв ийм шаардлага байхгүй бол агаарын тээврийн компани эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу шинж тэмдэгтэй эсвэл өндөр халуурсан ажилтныг гэртээ байх журам боловсруулж, мэдээлэх;
- Онгоцонд суух хэсэгт болон онгоцонд зорчих хүмүүсийн тооны хязгаарт тавих хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээ авч, аюулгүй байдлыг дэмжих бодлого, удирдамжийг хэрэгжүүлсэн байх;
- Нисэх онгоцны буудал, нийтийн хоолны үйлчилгээ, тээврийн түнш зэрэг гол оролцогч талууд ижил төстэй удирдамжийг хэрэгжүүлсэн байх;
- Одоо ашиглаж буй техник технологид шинэчлэлт хийх, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх, ашиглах боломжуудыг судалсан байх. Үүнд зайнаас төлбөр хийх, биометрийн танилт зэрэг технологи багтаж болно. Мөн зорчигч өөрөө өөрийгөө шалган нэвтрүүлэх бөгөөд ачаа өгөх, гэртээ хэвлэсэн ачааны шошго, нисэх буудлын гадна бүртгэл хийх, онгоцонд суух тасалбарыг автоматаар уншдаг е-хаалга гэх мэт зорчигчдын зайнаас харьцахад туслах үйл явцыг авч үзэх;
- Хоорондын зайтай холбоотой эрсдэлд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх, зорчигч болон ажилтнуудад тодорхой мэдээлж байх;
- Засгийн газар болон олон улсын эрүүл мэндийн байгууллагуудаас санал болгож буй ариун цэвэр, халдваргүйтгэлийн технологийн шинэчлэлтийг нэвтрүүлэх боломжийг судлах, шилдэг туршлагыг хуваалцах;
- Ажилтнуудыг хамгаалалтын халхавч болон амны хаалт, бээлий гэх мэт хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ)-ээр хангах;
- Тухайн улс орнууд эрүүл мэндтэй холбоотой бүхий л шинэ арга хэмжээ болон холбогдох зардлыг санхүүгийн хувьд хариуцах;
- Онгоцон доторх хүнсний аюулгүй байдлын удирдамж боловсруулж, хэрэгжүүлэх.

• Агаарын тээврийн компаниуд шинэ нөхцөл байдалд ажилтнуудаа дараах байдлаар бэлтгэн, сургасан байна:

  - Ажилтнуудын зан төлвийн болон үйл ажиллагааны зааварчилгаа бэлдсэн байх;
  - Халдварыг хянах, хүн хоорондын зай барих, гараа тогтмол угаах, маск, бээлий хэрэглэх тухай үндэсний хэмжээнд мөрдөж буй дүрэм, журам, түүнчлэн илүү нарийвчилсан арга хэмжээ авах талаар агаарын тээврийн байгууллагын дотоод журам байгаа бол эдгээр сэдвээр ажилтнуудаа давтан сургах;
  - Бүх сургалтад ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх;
  - Нисэх буудлууд, нийтийн хоолны газар, тээврийн компани зэрэг хамтран ажилладаг байгууллагуудад ижил төстэй сэдвээр ажилтнуудаа сургасан байхад анхаарах;
  - Ажилтны эрүүл мэндэд байнгын анхаарал хяналт тавьж, тэднийг Засгийн газар болон ДЭМБ-ын заавар зөвлөмжийг даган мөрдөхөд нь урамшуулан, манлайлж ажиллах;
  - Ажилтнуудын сэтгэл зүй, стресс зэрэг асуудлыг удирдах хөтөлбөртэй байх.

# 2.ХАРИУЦЛАГАТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ

**Агаарын тээврийн салбар болон агаарын тээврийн комданиуд аюулгүй, найдвартай туршлагаар дамжуулан багийн гишүүдийн болон зорчигчдын итгэлцэл, итгэлийг сэргээх чиглэлээр ажиллахдаа дараах арга хэмжээ авсан байна. Үүнд:**

- Эрчимжүүлсэн ариутгал, халдваргүйтгэл, гүн цэвэрлэгээний арга хэмжээг ойр давтамжтай хийхэд чиглэсэн дүрэм, журам боловсруулсан байна.
    - Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
    - Онгоцны угаалгын өрөө, онгоцонд бүртгүүлэх болон суух талбайд ялангуяа гар болон биеэр хамгийн их хүрэлцэх хэсгүүдийг цэвэрлэхэд онцгой анхаарал хандуулсан онгоцны бүх хэсэгт цэвэрлэгээ хийх зааварчилгааг шинэчлэх;
    - Онгоцонд бүртгүүлэх болон суух талбай зэрэг хөдөлгөөн ихтэй хэсэгт хэрэглэхийг зөвшөөрсөн спиртэн суурьтай гар ариутгагчийг бэлэн байлгах. Зорчигч, жуулчдад зориулж ариутгалын нэмэлт бүтээгдэхүүнийг өгөх эсвэл худалдан авах боломжтой болгох.

- Агаарын тээврийн болон нисэх онгоцны буудлын үйл ажиллагааны тасалдлыг багасгах зорилгоор шаардлагатай тохиолдолд зорчигчдын эрүүл мэндийн байдал, хувийн мэдээллийг шалгах арга хэмжээг нэвтрүүлэх, эмнэлгийн нотолгоо гаргах:
    - Засгийн газрын байгууллагуудын цахим хэрэгслээр дамжуулан онгоцонд суухаас өмнө эрүүл мэндийн эрсдлийг үнэлэх/өөрийн мэдэгдэл гаргах, энэхүү мэдэгдэлд үндэслэн зорчигчийг тээвэрлэх эрх нь нээгдэх салбарын хэмжээний журмыг танилцуулсан, үр дүнг зорчигчид шууд мэдэгддэг байх; онгоцноос буухад саатал гарахгүй байх зорилгоор энэхүү арга хэмжээг Засгийн газрууд харилцан хүлээн зөвшөөрсөн байх;
    - Засгийн газрын зүгээс зорчигчдыг COVID-19 шинжилгээнд шууд хамруулах, ингэхдээ зорчигчдын эрхэнд халдахгүй байдлаар түргэн шуурхай зохион байгуулах, тухайн зорчигч нисэж болох үгүй эсэхийг агаарын тээврийн компаниудад мэдээлэх;
    - Засгийн газруудаас хавьтлыг тогтоох олон улсын стандартыг цахим хэлбэрээр хэрэглэх;
    - Орц, гарцад зайлшгүй шалгалт хийх тохиолдолд зайнаас ялангуяа харьцах байдлаар хийх, жишээлбэл бүтэн биеийн хэт улаан туяаны скайнер, хэт улаан туяаны гар термометр, чихний термометр гэх мэт төхөөрөмж ашиглах. Үүнийг терминал руу нэвтрэх цэгт эсвэл хамгаалалтын шалган нэвтрүүлэх цэгээс өмнө, гаалийн байгууллага, ачаа тээш авах газарт хэрэгжүүлэх ёстой. Улс хооронд ижил төстэй аргачлалтай байх. Ирсэн улсын агаарын тээврийн компанийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжаар зохицуулагддаг нислэгийн багийн хувьд тэднийг ирэх үед эрүүл мэндийн үзлэг, хорио цээрийн шаардлагаас чөлөөлөх;
    - Эрх бүхий байгууллагаас зорчигчдыг гараар нэгжих, нүүр тулан шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг багасгасан журмыг орон нутгийн хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх;
    - Биеэр хүрэх, дараалж зогсох зэрэг нөхцлийг бууруулж ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, зарлан мэдэгдэх. Аяллын туршид хоорондын зай барих, дарааллыг аль болох багасгах арга хэмжээ авсан байх;
    - Бүртгэлийг аль болох цахимаар хийх;

- Зорчигчид хооронд болон ажилтнуудын хоорондын зай барих зорилгоор өөрөө ачаа тээшээ хэмжиж, бүртгүүлэх аргачлалыг хэрэгжүүлэх;
- Хэрэв тухайн зорчигчийн мэдүүлэг шаардлагатай тохиолдолд хүн хоорондын харилцааг багасгах зорилгоор Засгийн газрууд цаасан бичиг баримтын оронд цахим хэлбэрийн аргыг ашиглаж, хэрэгжүүлэх. Хүлээн авах танхимыг Засгийн газар, нисэх онгоцны буудал, агаарын тээврийн компанитай хамтран дахин төлөвлөх;
- Ачаа тээшийг буулгах ажлыг түргэвчлэхэд онцгойлон анхаарах, хавьтал үүсэх боломжтой учир зорчигчдыг ачаа тээшээ хүлээж авах хэсэгт удаан хүлээлгэхгүй байх.

- Онгоцонд зорчигчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх:
  - Эрсдлийн үнэлгээгээр нислэгийн хугацаанд зорчигчдод амны хаалт зүүх шаардлага тавих;
  - Онгоцонд суух үйл явцыг шинэчлэх (араасаа урагшаа, эхлээд цонхон талаас дараа нь голын эгнээнүүдэд);
  - Бүхээг доторх хөл хөдөлгөөнийг аль болох хязгаарлах;
  - Зорчигчид өөрсдөө хоолоо авч идэхээс зайлсхийх, үйлчилгээ авах, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсан байх. Ариутгаж, боосон нэг удаагийн хэрэгсэл ашиглах, савласан хоол өгөх.

# 3.ЗОРЧИГЧДЫН ИТГЭЛИЙГ СЭРГЭЭХ

**Агаарын тээврийн салбар үйлчилгээний ил тод байдал, найрсаг харилцаанд тулгуурлан зорчигчдын итгэлийг сэргээхийн тулд дараах зүйлс дээр анхаарна. Үүнд:**

- Онгоцон дотор болон нисэх буудалд байгууллагын дижитал болон шууд сувгийг ашиглан эрүүл мэнд/эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод байдлаар тогтмол хүргэх. Зочидтой байнга харьцдаг үйлчилгээний ажилтнуудыг эрүүл мэндийн холбоотой асуултад хариулах чадвартай болгон сургаж бэлтгэх;
- Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу амны хаалт зүүх, гарын ариун цэврийг сахих зэрэг мэдээллийг агуулсан аяллын явцад шаардлагатай мэдээллийг аяллын өмнө тогтмол мэдээлж байх;
- Бүртгэлийн цэг, онгоцонд суух талбай зэрэг хөдөлгөөн ихтэй хэсэгт хэрэглэхийг зөвшөөрсөн спиртэн суурьтай гар ариутгагчийг зорчигчдод зориулан бэлэн байлгах. зорчигч, жуулчдад зориулж ариутгалын нэмэлт бүтээгдэхүүнийг өгөх эсвэл худалдан авах боломжтой болгох;
- Зорчигчдод онгоцонд суух хэсэгт болон дотор талд бөөгнөрөл үүсгэх асуудал үүсгэхгүйн тулд, аюулгүй байдлыг дэмжихийн тулд зааварчилгаа өгөх;
- Цэвэрлэгээний зөвлөмж, зай барих болон бусад зөвлөмжийн талаар зорчигчдад мэдээлэхийн тулд тодорхой тэмдэг тэмдэглэгээг хэрэгжүүлэх;
- Төрийн байгууллагуудтай хамтран хавьтлыг мөшгөх аппликейшн ашиглах;
- COVID-19-ийг хамарсан аялал жуулчлалын даатгалыг гуравдагч талтай хамтран зорчигчдад санал болгох.

# 4.УРАМШУУЛЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Агаарын тээврийн салбар эргэж сэргэхэд Засгийн газрын дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Иймээс салбарынхан Засгийн газарт дараах хүсэлт тавих хэрэгтэй:**

- Цалингийн татвар, аж ахуйн нэгжийн албан татвар, концессын төлбөр, Засгийн газрын салбараас авч буй татвараас хөнгөвчлөх замаар салбартаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрууд аялал жуулчлалын бодлогын өөрчлөлтийг ил тод байдлаар тухай бүрд нь цаг алдалгүй урьдчилан мэдээллэх;
- Нийгмийн эрүүл мэндийг хангасан олон улсын дамжин өнгөрөх аялал жуулчлалыг дахин эхлүүлэхэд уялдаатай хандлагыг санал болгох;
- Зорчигчдын эрүүл мэндийн мэдээллийг олж авах (өөрийн мэдэгдэл) дэлхийн хэмжээнд нийцсэн аргуудыг хэрэгжүүлж, агаарын тээврийн компаниудад буцааж хүлээн авсныг баталгаажуулах стандарт арга замыг бий болгох;
- Бусад орны Засгийн газрын гаргасан шинжилгээний хариуг хүлээн зөвшөөрөх, ингэхдээ жуулчдын найдвартай, баталгаатай бичиг баримтыг паспорттой нь тулгаж үзэх;
- Агаарын тээврийн салбарыг авч үлдэхийн тулд бага хүүтэй эсвэл хүүгүй зээл олгох, зээлийн баталгаа эсвэл шууд туслалцаа үзүүлэх;
- Виз олголтын үйл явцыг хялбаршуулж бас хямдруулах замаар виз олголтыг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлалын эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор урамшууллыг бий болгох, татварын хөнгөлөлт үзүүлэхээс гадна шууд дэмжлэг үзүүлэх;
- Аялал жуулчлалын дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зорин очих газрын сурталчилгааг сайжруулах.








# БОГИНО ХУГАЦААНЫ ТҮРЭЭС

WORLD TRAVEL & TOURISM COUNCIL

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ



# ТАНИЛЦУУЛГА

Энд өгүүлж буй богино хугацааны түрээсийн үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан удирдамжийг Засгийн газрын итгэмжлэгдсэн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байгаа салбарын тэргүүлэгч компаниуд, мэргэжлийн холбоодын саналд тулгуурлан боловсруулласа.

Уг удирдамжийн зорилго нь  жуулчдын хэрэгцээ, хүлээлттэй уялдуулан эрүүл мэнд, аюулгүй байдал, хүн хоорондын зай барих шаардлагад илүү анхаарал хандуулсан холбогдох бүх чиг үүргийн нэгдсэн стандартыг бий болгоход оршино.

Эдгээр зөвлөмжүүд өөрчлөгдөж болох бөгөөд халдварын нөхцөл байдалд үндэслэн сайжруулж, вирус тархах эрсдэлгүй болсны дараа цуцалж болохыг анхаарна уу. Энэхүү мэдээлэл нь богино хугацааны үйл ажиллагааны шинж чанарт тулгуурласан бөгөөд хэрэгжүүлэхээс өмнө холбогдох талуудтай зөвлөлдөх шаардлагатайг анхаарна уу. Богино хугацааны түрээсийн бүх үйлчилгээ нь орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон / эсвэл Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) зэрэг дэлхийн нийгмийн эрүүл мэндийн байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн зааварчилгааг дагаж мөрдөхийг зөвлөж байна.

Тодорхойлсон арга хэмжээ нь халдвар тархах өндөр эрсдэлтэй нөхцөл байдалд тулгуурласан болохыг тэмдэглэх нь чухал юм. Тиймээс богино хугацааны түрээсийн үйлчилгээ нь зохицуулалтыг орон нутгийн, үндэсний болон/эсвэл дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зааварчилгаа, хууль тогтоомжтой уялдуулах шаардлагатай. Арга хэмжээг хэрэгжүүлэхдээ тодорхой цаг хугацаанд хязгаарлах бөгөөд нийгмийн эрүүл мэндийн мэдээлэлд үндэслэн дахин үнэлж, тогтмол хяналт тавьж байх ёстой. Мөн илүү үр дүнтэй арга хэмжээ авах боломжтой бол тэдгээрийг тэргүүнд хэрэгжүүлж, бүтээмжгүй арга хэмжээг хүчингүй болгох хэрэгтэй. Жижиг, дэнд аж ахуйн нэгжүүд нь  зочид, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах хэд хэдэн арга хэмжээ байгаа бол хамгийн бага зардалтайд нь давуу эрх олгох хэрэгтэй.

Санал болгож буй удирдамж нь богино хугацааны түрээсийн үйлчилгээ эрхлэгчдийн хэрэгжүүлэх боломжтой баримт бичиг бөгөөд үйлчилгээ эрхлэгчид болон зочдын хооронд харилцаа тогтоох талбар биш юм. Гэсэн хэдий ч у талбар нь удирдамжийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай.

Ойлгомжтой байлгах үүднээс дараах нэр томьёоны тайлбарыг оруулав. Үүнд:

- **Богино хугацааны түрээс:** Үндэсний болон орон нутгийн хууль тогтоомжоор тогтоосон хугацааны хүрээнд зочдод түрээслүүлэх боломжтой бүрэн тавилгатай орон сууц, гараж эсвэл зоорийн давхарт байрлах орон сууцны хэсэг, бусад түрээслэх боломжтой орон зай.

- **Богино хугацааны түрээсийн үйлчилгээ үзүүлэгч:** Өмчлөгч, түрээслэгч, лиценз эзэмшигч, эзэмшигчийн асран хамгаалагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хүлээн авагч, гүйцэтгэгч эсвэл өөр бусад эрхтэй богино хугацааны түрээсийн эзэн, ЖДҮ эрхлэгч эсвэл хөрөнгийн менежментийн компани.
- **Богино хугацааны түрээсийн талбар:** Зочдыг богино хугацааны орон байрны түрээсийн үйлчилгээ эрхэлдэг мэргэжлийн эсвэл мэргэжлийн бус үйлчилгээ үзүүлэгчтэй тодорхой төлбөртэй нөхцөлөөр холбох зуулчлалын үйлчилгээ.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй бүхий л этгээдэд илүү хялбар болгохын тулд удирдамжийг дараах 4 бүлэгт хуваасан болно. Үүнд:

1. **Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Аялагчдын итгэлийг сэргээх**
4. **Урамшууллын бодлого хэрэгжүүлэх**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЖИЛТНУУДЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

**Богино хугацааны түрээсийн бизнес эсвэл богино хугацааны түрээсийн үйлчилгээ эрхлэгч нь үйл ажиллагаагаа дахин нээхийн тулд гүйцэтгэлийн чанар болоод хүргэлтийг оновчтой болгох хэрэгтэй. Түүнчлэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд богино хугацааны түрээсийн үйлчилгээний салбарын олон нийтийг сургах, тэдний оролцоог хангах нь чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүнээс гадна богино хугацааны түрээсийн үйлчилгээ эрхлэгчдэд тусгайлан зориулсан ажилтан байдаггүйгээс цэвэрлэгээний үйлчилгээг гадны байгууллагаар хийлгэж болох боловч аюулгүй байдлыг дор дурдсанаар эн тэргүүнд тавих нь чухал юм.**



- Богино хугацааны түрээсийн үйлчилгээ эрхлэгч дараах нөхцлийг бүрдүүлснээр дахин нээх боломжтой юм. Үүнд:
  - Халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны жагсаалт/хяналтын хуудас, цэвэрлэгээ, ариутгалын тусгай төлөвлөгөө зэрэг COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг байх;
  - Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдамжийг хэрэгжүүлэх, үүнд дотоодын хууль тогтоомжид заасны дагуу богино хугацааны түрээсийн ажилтанг эрүүл мэндийн үзлэгт хамруулах;
  - Нийгмийн эрүүл мэндийн байгууллагууд болон/эсвэл ДЭМБ-ын зааварчилгааны дагуу халдварын шинж тэмдэгтэй эсвэл өндөр халуунтай ажилтныг гэртээ байх журам боловсруулж, мэдээлэх;
  - Мэргэжилтнүүд, эрүүл мэндийн байгууллагууд, Засгийн газрын агентлагуудаас баталгаажуулсан цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн шилдэг туршлагыг тодорхойлж, сургасан байх;
  - Боломжтой бол зайнаас төлбөр, бүртгэл хийх төхөөрөмж зэрэг автоматжуулсан технологи нэвтрүүлэх; хэрэв зайнаас төлбөр хийх боломжгүй бол бээлий, гар ариутгагч ашиглах;
- Богино хугацааны түрээсийн үйлчилгээ эрхлэгч үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх зорилгоор ажилтнуудаа дараах байдлаар сургасан байна. Үүнд:
  - Богино хугацааны түрээсийн үйлчилгээ эрхлэгчид хэрэглэхэд хялбар эрүүл ахуй, халдваргүйтгэлийн удирдамж боловсруулсан байх;
  - Халдварыг хянах, эрүүл ахуйн сайжруулсан арга хэмжээ авах, хүн хоорондын зай барих шаардлага, түүнчлэн дотоодын эрүүл мэндийн байгууллагын зааврын дагуу гар угаах, маск, бээлий хэрэглэх тухай мэдээлэл, хэрэгслээр хангах;
  - Бүх сургалтад ДЭМБ болон бусад нийгмийн эрүүл мэндийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх;
  - Дотоодын хууль тогтоомжийн хүрээнд ажилтны өвчний чөлөө олгох журмыг хянаж, шаардлагатай бол шинэчлэх.



## 2.ХАРИУЦЛАГАТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

**Богино хугацааны түрээсийн үйлчилгээ эрхлэгч нь цэвэрлэгээ, эрүүл ахуйн шилдэг туршлагаар дамжуулан зочдын аюулгүй байдлыг хангахын тулд дараах арга хэмжээг авна.**

- Эрчимжүүлсэн ариун цэвэр, ариутгал, халдваргүйтгэл, гүн цэвэрлэгээний арга хэмжээг өндөр давтамжтай хийхэд чиглэсэн дүрэм журам тогтоосон байна:
  - Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
  - Унтлагын өрөө, нийтийн өрөө, угаалгын өрөө, гал тогооны өрөө, аяга таваг хэрэгслийн ариутгал зэрэг гар болон биеэр хамгийн их хүрдэг хэсгүүдийг цэвэрлэхэд онцгой анхаарсан цэвэрлэгээний зааварчилгааг давтан өгөх;
  - Ваар, олдвор зэрэг гадны зүйлийг хураах;
  - Зочдыг байх хугацаандаа цэвэрлэгээний үйлчилгээнээс татгалзах боломжийг олгох;
  - Шаардлагатай тохиолдолд цахилгаан шатанд тэмдэг тэмдэглэгээ байрлуулах зэргээр хүн хоорондын зай барихыг зочдод сануулах;
  - Богино хугацааны түрээсийн байрны орох хэсэгт ариутгах цэгүүд дээр спиртэн суурьтай, эсвэл гипохлоридийн хүчил агуулсан гар ариутгагч зэрэг ариутгал, халдваргүйтгэлийн бүтээгдэхүүнийг ашиглахыг зөвлөх;
  - Гараа тогтмол бөгөөд зөв угааж байхыг дэмжиж, боломжтой бол цаасан алчуураар хангах;
  - Ажилтнуудад нэг удаагийн бээлий, хормогч, хамгаалалтын хувцас, нүүрний маск зэрэг хувийн хамгаалах хэрэгслийг ашиглахыг дэмжих;
- Мэдээлэл солилцох, хүн хоорондын зай барих шаардлагатай холбоотой зочдод мэдээлэл хүргэх:
  - Шаардлагатай тохиолдолд зочдыг ирэхээс өмнө эрүүл мэндийн асуумж бөглүүлсэн байх;
  - Зочдод түлхүүр өгч авахдаа биеэр харьцах нөхцлийг багасгах, ялангуяа ирэх буцах тооцоог цахимаар, зайнаас хийх;

## 3.АЯЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ СЭРГЭЭХ

**Богино хугацааны түрээсийн салбар болон үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний ил тод байдал, найрсаг харилцаанд тулгуурлан аялагчдын итгэлийг сэргээхийн тулд дараах зүйлс дээр анхаарна. Үүнд:**

Захиалга хийхээс өмнө болон ирэхийн өмнө байгууллагын дижитал болон шууд сувгийг ашиглан эрүүл мэнд, эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод байдлаар тогтмол хүргэх. Сайжруулсан цэвэрлэгээний удирдамжийн талаар болон зай барих шаардлагыг тодорхой тэмдэглэгээ эсвэл цахимаар зочдод мэдээлэх;

- Эрүүл мэндийн байгууллагын зөвлөгөөг үндэслэсэн амны хаалт зүүх, гараа угаах, зай барих шаардлага зэрэг зааварчилгааг олон нийт, зочдод боломжтой бол богино хугацааны түрээсээр ирэхийн өмнө, эсвэл биечлэн танилцуулах;

- Асуулт эсвэл асуудал гарвал дэмжлэг үзүүлэх боломжтой талаар зочдод мэдээлэх. Үйлчилгээ үзүүлэгч нь зочдыг ирэхээс өмнө болон байрлах хугацаанд тэдний асуултад хариулах, тайвшруулах, түүнчлэн зочдыг дотоодын бусад холбогдох нөөцөд чиглүүлж, зочид байх хугацаанд нөлөөлж болзошгүй аливаа дотоодын тодорхой дүрэм журмыг танилцуулахад бэлтгэгдсэн байх; Зочдод үйлчилгээ үзүүлэгчийн төдийгүй зочдын өөрсдийн хариуцлагыг мэдэгдэх.

# 4.УРАМШУУЛЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Аялал жуулчлалын эдийн засгийг сэргээхэд Засгийн газар нь аялал жуулчлалыг дэмжих, богино хугацааны түрээсийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг бүх төрлийн орон сууцны санхүүгийн эрүүл нөхцлийг хангах чиглэлээр салбарынхантайгаа уялдаатай ажиллах нь чухал юм. Үл хөдлөх хөрөнгийн операторууд эсвэл үл хөдлөх хөрөнгийн менежментийн жижиг, том бизнес эрхлэгчдийн хувьд бүгд энэ салбарт үүрэг гүйцэтгэх ёстой.**

- Хил дамнасан аяллын шинэ дүрмийг боловсруулахад хамтран ажиллах;
- Богино хугацааны түрээсийн салбар цаашдын хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах нөхцлийг нь бататгаж, бүс нутаг болоод улс орон дамнасан энэхүү салбарын төрөл бүрийн байгууллагуудыг хамарсан уялдаа холбоотой, үр дүнтэй, оновчтой, энгийн удирдамжийг хэрэгжүүлэх;
- Татвар, төлбөр, хураамжийг бууруулах замаар салбарт санхүүгийн туслалцаа үзүүлэн эрэлтийг өдөөх;
- Богино хугацааны түрээс, татварын урамшууллыг уртасгах, шууд дэмжлэг үзүүлэх;
- Дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зорин очих газрын сурталчилгааг сайжруулах.






# ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭ

WORLD TRAVEL & TOURISM COUNCIL

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ



# ТАНИЛЦУУЛГА

Аялал жуулчлалын салбар бүхэлдээ хямралд өртсөнөөс хойш туршлагадаа тулгуурлан ирээдүйгээ тодорхойлох асар том мэдээллийн сантай болжээ. Тиймээс хямралын үед зочлох үйлчилгээний салбар үүсээд буй нөхцөл байдалд хурдан дасан зохицсон юм. Үүгээр ч зогсохгүй зарим зочид буудлууд цар тахалтай тэмцэж буй эрүүл мэндийн ажилтнуудад үүдээ нээсэн нь эргээд аюулгүй аяллын шинэ санаа, өвөрмөц туршлагыг бий болгожээ.

Хэрхэн эрүүл, аюулгүй нөхцөл бүрдүүлж, зочид буудлаа хариуцлагатайгаар дахин нээх тухай шилдэг компаниуд мэдээллээ олон нийтэд нээлттэй тавьсан юм. Энэхүү мэдээллийг эмхэтгэн, зочлох үйлчилгээний талаар дараах удирдамжийг хүргүүлж байна. Мөн аялагчдын хүсэн, хүлээж буй аюулгүй байдлыг эрхэмлэсэн удирдамжийг холбогдох бүх үйл ажиллагаанд нэвтрүүлэхийн тулд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төв (ӨХТ)-ийн удирдамжаас иш татсан болно. Цаашид вирусийн тухай мэдээлэл нэмэгдэхийн хэрээр эдгээр практик удирдамж нь шинэчлэгдэн, сайжрахыг анхаарна уу.

Зочид буудал бүр өөрийн онцлогтоо тохируулан дараах удирдамжийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Мөн хууль, орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй дүрэм, журам, нийгмийн эрүүл мэндийн байгууллагуудын зөвлөмжийг бүх зочид буудлууд үйл ажиллагаандаа нэвтрүүлж, дагаж мөрдөх нь зүйтэй.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бүх хүнд илүү хялбар болгох үүднээс удирдамжийг дараах 4 бүлэгт хуваасан. Үүнд:

1. **Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Аялагчдын итгэлийг сэргээх**
4. **Бодлогын түвшинд дэмжлэг авах**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЖИЛТНУУДЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

**Зочлох үйлчилгээний салбар, аж ахуй нэгж үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Юуны түрүүнд зочлох үйлчилгээний салбар, байгууллагууд шинэ нөхцөл байдалд үйл ажиллагаагаа хэвийн явуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажилтнуудаа бэлтгэсэн байх шаардлагатай.**

- Дараах нөхцлийг бүрдүүлсэн зочид буудлын үйл ажиллагааг дахин эхлүүлэх боломжтой. Үүнд:
  - Засгийн газраас үйл ажиллагаагаа явуулах, дахин сэргээхэд шаардагдах бүх зөвшөөрөл, лиценз авсан байх;
  - Ковид19 цар тахлын халдвараас урдчилан сэргийлэх арга хэмжээ /хяналтын хуудас, тусгай ариутгал, цэвэрлэгээ г.м зүйлсийг багтаасан/-ний цогц төлөвлөгөө боловсруулах;
  - Үйл ажиллагааг дахин эхлүүлэхэд шаардагдах хангалттай ажилтантай байх;
  - Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийг боловсруулах, үүнд, үндэсний хэмжээнд мөрдөж буй зохицуулалтын дагуу ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах заалт оруулах, хэрэв ийм шаардлага байхгүй бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу шинж тэмдэгтэй эсвэл өндөр температуртай ажилтныг гэртээ байх журам боловсруулж, мэдээлэх;
  - Дотоодын аяллын хөтөч болон тээврийн компаниудын холбогдох дүрэм, журамтай уялдуулсан байх;
  - Оффист хүн хоорондын зайг баримталсан зохион байгуулалтыг шинээр хийх, амрах өрөөнүүдэд нэг дор байх ажилтнуудын тоог хязгаарлах;
  - Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан хүн хоорондын зай барих шаардлага, удирдамжийг дагаж мөрдөх, боломжтой бол, зочид, ажилтнуудад танигдахаар тодорхой тэмдэглэгээ хийсэн байх;
  - Боломжтой бол зайнаас төлбөр хийх төхөөрөмж гэх мэт автоматжуулсан технологи нэвтрүүлэх;



- Ресторан, кофе шоп, хоолны мухлаг зэрэг газруудад хүнсний аюулгүй байдалтай холбоотой хангамжийн сүлжээний хяналт, хоол, хүнс боловсруулах, бэлдэх, эрүүл ахуй, ариун цэвэр, автоматжуулалт, дарааллын менежмент, гүн цэвэрлэгээ зэрэг асуудлаар дүрэм, журам тогтоож, хэрэгжүүлдэг байх;
- Засгийн газар, ДЭМБ зэрэг байгууллагуудаас баталгаажуулсан электростатик шүршигч технологи, UVC гэрэл болон EPA-д суурилсан агаар шүүгч зэрэг ариутгал, халдваргүйтгэлийн орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх боломжийг судалж, шилдэг туршлагыг хуваалцах.

• Зочид буудлууд үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх хүрээнд ажилтнуудыг дараах байдлаар сургаж, бэлтгэсэн байна. Үүнд:

  - Ажилтнуудад зориулсан дотоод журам, ёс зүйн дүрэм, ажилтнуудын зан төлвийн болон үйл ажиллагааны зааварчилгаа бэлдсэн байх;
  - Халдварыг хянах, хүн хоорондын зай барих, гараа тогтмол угаах, маск, бээлий хэрэглэх тухай үндэсний хэмжээнд мөрдөж буй хууль тогтоомж, түүнчлэн илүү нарийвчилсан арга хэмжээ авах талаар зочид буудлын дотоод журам байгаа бол эдгээр сэдвээр ажилтнуудаа давтан сургах;
  - Бүх сургалтад ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх;
  - Ажилтнуудын эрүүл мэндэд байнгын анхаарал хяналт тавьж, тэднийг Засгийн газар болон ДЭМБ-ын заавар зөвлөмжийг даган мөрдөхөд нь урамшуулан, манлайлж ажиллах.

# 2.ХАРИУЦЛАГАТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

**Зочлох үйлчилгээний салбар, байгууллагууд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхдээ эрүүл ахуйн шилдэг туршлагыг нэвтрүүлж, ажилтнууд болон аялагчдын аюулгүй байдлыг хангахын тулд дараах нөхцлийг бүрдүүлсэн байна:**

• Эрчимжүүлсэн ариутгал, халдваргүйжүүлэлт, гүн цэвэрлэгээний арга хэмжээг ойр давтамжтай хийхэд чиглэсэн дүрэм, журам боловсруулсан байна.

  - Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
  - Зочны өрөө, угаалгын өрөө, цахилгаан шат, биеийн тамирын заал, хүлээлгийн өрөө зэрэг зочид буудлын бүх талбайн цэвэрлэгээний зааврыг шинэчлэхдээ гар болон биеэр хамгийн их хүрэлцэх хэсгүүдийг /өрөөний түлхүүр, карт, гэрлийн унтраалга, хаалганы бариул г.м/ цэвэрлэхэд онцгой анхаарах;
  - Онцын шаардлагагүй эд хогшлыг зочид буудлаас зайчлах;
  - Зочид буудалд бүртгүүлэх, цахилгаан шатаар зорчих үед хүн хоорондын зайг баримтлах дүрмийг мөрдүүлэх.

• Үйлчлүүлэгчид чиглэсэн зочдын мэдээлэл, хүн хоорондын зай барих шаардлага зэрэг мэдээллийг багтаасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

  - Хууль тогтоомжийн шаардлагын дагуу зочдын эрүүл мэндийн хяналтыг хэрэгжүүлэх;
  - Бүртгэлийн хэсэгт зайнаас харьцах нөхцлийг дэмжиж, дугаарлаж зогсох нөхцлийг хязгаарласан байх;
  - Эрсдэлд суурилсан хандлагын дагуу шаардлагатай бол маск хэрэглэхийг зөвлөх.

- Зочид буудлын ресторанд хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн дараах шаардлагыг хангасан байх:
  - Буфетийн хэсэгт зочдыг өөрсдөөр нь хүнсэнд хүргүүлэхгүй байх;
  - Цай, кофены машиныг тогтмол цэвэрлэх, боломжтой бол үйлчлэгч ажиллуулах;
  - Цар тахлын халдвараас урдчилан сэргийлэх тохиромжтой шийдэл учир зочдод өрөөний үйлчилгээг санал болгох;
  - Зочдыг гармагц ширээг халдваргүйжүүлж, нэн даруй цэвэрлэх;
  - Ширээ, зочдын суудал хоорондын зай барих шаардлагыг баримтлах;
  - Зочдын ширээн дээр тавих эд зүйлсийн тоог багасгаж, боломжтой бол багцалж, ариутгасан хэрэгсэл ашиглах.
- Хурал болон бусад олон нийтийг хамарсан арга хэмжээний үед ариун цэвэр, халдваргүйтгэл, хүн хоорондын зай барихад чиглэсэн журмыг хэрэгжүүлсэн байх:
  - Хурал болон бусад олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр эрх бүхий байгууллагын удирдамжийн дагуу суудлын хуваарилалт хийж, цуглах хүний тоонд хязгаар тавих замаар хүн хоорондын зай барих шаардлагыг баримтлах;
  - Төхөөрөмжүүдийг тогтмол цэвэрлэх, боломжтой бол үйлчлэгч ажиллуулах;
  - Ариутгал, халдваргүйтгэлийн давтамжийг нэмэх;
  - Зочдод ус болон уух зүйлстэй холбогдуулан санамж бэлдэх. Хэрэв танхим ус цэвэршүүлэгчтэй бол аль болох зочдыг өөрсдийн усны савтай ирэхийг уриалах эсвэл хуралд зориулан бэлэн байлгах:
  - Гаднаас хоол хүнс оруулж буй тохиолдолд түүнийг зохицуулсан журамтай байх.



# 3.АЯЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ СЭРГЭЭХ

**Зочлох үйлчилгээний салбар, байгууллагууд үйлчилгээний ил тод байдал, найрсаг харилцаанд тулгуурлан аялагчдын итгэлийг сэргээхийн тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:**

- Байгууллагын дижитал болон шууд сувгийг ашиглан эрүүл мэнд/эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод байдлаар тогтмол хүргэх. Зочидтой байнга харьцдаг зочлох, угтах үйлчилгээний ажилтнуудыг эрүүл мэндийн холбоотой асуултад хариулах чадвартай болгон сургаж бэлтгэх;
- Зочид буудлын хэмжээнд эрчимжүүлсэн цэвэрлэгээ, хүн хоорондын зай барих шаардлагын талаар ойлгомжтой тэмдэглэгээнүүдийг зочдод харагдахаар байрлуулсан байх;
- Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу амны хаалт зүүх, гарын ариун цэврийг сахих, хүн хоорондын зай барих зэрэг мэдээллийг агуулсан зочдод зориулсан гарын авлага бэлтгэж, дүрэм журмыг тогтмол мэдээллэх.



# 4.УРАМШУУЛЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Зочлох үйлчилгээний салбар, байгууллагууд эргэж сэргэхэд Засгийн газрын дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Иймээс зочлох үйлчилгээний салбарынхан Засгийн газарт дараах хүсэлт тавих хэрэгтэй:**

- Хил дамнасан аяллын шинэ дүрмийг боловсруулахдаа салбарын байгууллага болон бусад орны Засгийн газруудтай хамтран ажиллах;
- Татвар, төлбөр, хураамжийг бууруулах замаар салбарт санхүүгийн туслалцаа үзүүлэн эрэлтийг өдөөх;
- Зочид буудалд байрлаж, татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх урамшууллыг бий болгох, шууд дэмжлэг үзүүлэх;
- Дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зорин очих газрын сурталчилгааг сайжруулах.

# COVID-19 ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨГӨӨ, ЗӨВЛӨМЖ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

## КАФЕ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АЖИЛЧДЫН КОРОНАВИРУСТ (COVID-19) ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ



### АЖЛЫН БАЙРАН ДЭЭР

- Амны хаалт зүүсэн үйлчлүүлэгчдэд үйлчлэх ба нэвтрэхээс өмнө биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх;
- Хуванцар хаалтаар ширээ хооронд тусгаарлалт хийх
- Хүн хоорондын зайг 1,5-2 метр байх нөхцөлийг бүрдүүлж ажлын байранд зай барьж үйлчлүүлэх тэмдэг, тэмдэглэгээг байршуулах
- Үйлчүүлэгчдэд утсаар эсвэл цахимаар цаг өгч үйлчлэх
- Ажлын байранд 14 хоног тутамд тусгай зөвшөөрөлтэй халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх
- Өдөрт 1-2 цаг тутамд 15 минутын турш салхивчийг нээн агаар сэлэлт хийх ба агааржуулалтын системийг тогтмол ажиллуулах
- Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, хаалганы бариул, гэрлийн унтраалга, сандал, ширээ, шүүгээ гэх мэт хүний гар хүрэх бүх эд зүйлсийг 2 цаг тутамд халдваргүйжүүлэх бодистой уусмалаар шүрших, арчиж халдваргүйжүүлэх

### АЖИЛЧИД

- Амны хаалтыг тогтмол зүүх ба 2 цаг тутамд солих
- Нүүрний хаалт зүүх
- Амны хаалт зүүсэн үйлчлүүлэгчдэд үйлчлэх
- Үйлчлүүлэгчээс 1,5 метрээс дотогш зайд харьцахгүй байх
- Төлбөр тооцоог карт, гар утасны QPay үйлчилгээ ашиглан хийлгэх
- Ажилтан бүр хувцасны шүүгээтэй байх ба ажлын дараа хувцсыг тайлж үлдээх

### ГЭРТЭЭ ОРОХДОО

- Гадуур өмссөн гутал, хувцсаа тайлахдаа сэгсрэхгүй байх
- Бохирдсон нэг удаагийн бээлий маскыг тагтай хогийн саванд хаях
- Гараа сайтар угааж халдваргүйжүүлэх
- Давс, сода, нимбэгний уусмалаар ам хоолойгоо зайлах

habemt.gov.mn

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ААС СЭРГИЙЛЬЕ!

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

# ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БОЛОН ИРГЭДЭД

ЗОРИУЛСАН КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

# ЗӨВЛӨМЖ



**Алхам 1**

Ажлын байранд их цэвэрлэгээг тогтмол хийх, 14 хоног тутамд тусгай зөвшөөрөлтэй халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх

**Алхам 2**

Гэрийн тусгаарлалтад байгаа ажилчдыг тусгаарлалтын хугацаа дуустал ажлаас түр чөлөөлөх

**Алхам 3**

Үйлчлүүлэгч хоорондын зай 1.5-2 метр байх нөхцөлийг бүрдүүлэх, гадна хаалга болон үйлчилгээний танхимд "зай барьж үйлчлүүлэх тухай" тэмдэг, тэмдэглэгээг байршуулах

**Алхам 4**

Халуурсан болон шинж тэмдэг илэрсэн ажилтныг түр тусгаарлах өрөөг бэлдэх

**Алхам 5**

Хүнсний аюулгүй байдал алдагдсан, хугацаа дууссан түүхий эд, бүтээгдэхүүнийг байгууллагын дотоод хяналтын дор устгах

**Алхам 6**

Шаардлагатай цэгүүдэд спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх уусмал байршуулах



ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

# ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД



**АЛХАМ 1**

Ажил эхлэхээс өмнө ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг угааж цэвэрлэн халдваргүйжүүлэх

**АЛХАМ 2**

Ажилчдыг ажлын байранд нэвтрэхээс өмнө биеийн халууныг хэмжин, тандалт судалгааны асуумж авч, бүртгэл хөтлөх

**АЛХАМ 3**

Амны хаалт зүүсэн үйлчлүүлэгчдэд үйлчлэх, обьектод нэвтрэхээс өмнө биеийн халууныг хэмжиж спиртэн суурьтай уусмалаар гарыг халдваргүйжүүлэх

**АЛХАМ 4**

Биеийн халуун 2-3 удаагийн хэмжилтээр 37°С хэм буюу түүнээс дээш хэмжигдсэн хүнийг түр тусгаарлан эрүүл мэндийн байгууллагад мэдээлэх

**АЛХАМ 5**

Ариун цэврийн өрөө болон хүний гар хүрэх эд зүйлсийг 2 цаг тутамд халдваргүйжүүлэх бодистой уусмалаар арчиж халдваргүйжүүлэх

**АЛХАМ 6**

Ажлын байранд ажилтан амны хаалтыг тогтмол зүүх ба 2 цаг тутамд солих, нүүрний хаалт хэрэглэх, гарыг бохирдсон тухай бүрт халуун бүлээн усаар савандаж угаах, спиртэн суурьтай уусмалаар гарыг халдваргүйжүүлэх, үйлчлүүлэгчтэй харьцаж байгаа тохиолдолд нэг удаагийн бээлий өмсөх, үйлчлүүлэгчээс 1.5 метрээс доторш зайд харьцахгүй байх

**АЛХАМ 7**

Ажилтан бүр тусдаа шүүгээтэй байх ба ажлын дараа дүрэмт хувцсыг тайлж үлдээх

**АЛХАМ 8**

Өдөрт 1-2 цаг тутамд 15 минутын турш агаар сэлгэлт хийх ба агааржуулалтын системийг тогтмол ажиллуулах

**АЛХАМ 9**

Цэвэрлэгээ хийж байгаа ажилтан хөдөлмөр хамгааллын хувцсыг бүрэн өмсөж ажил үүргээ гүйцэттэх

**АЛХАМ 10**

Цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуурыг халдваргүйжүүлэх бодистой уусмалд 30 минут дэвтээсний дараа цэвэр усанд зайлж хатаах

**АЛХАМ 11**

Хог хаягдлаа төрөлжүүлэн, зориулалтын саванд цуглуулж, зайлуулах

**АЛХАМ 12**

Төлбөр тооцоог төлбөрийн карт, гар утасны QPay үйлчилгээ ашиглан төлөхийг сануулсан зөвлөмжийг кассын дэргэд байршуулах, бэлэн мөнгөөр гүйлгээ хийхээс аль болох зайлсхийх

habemt.gov.mn






# НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ

WORLD TRAVEL & TOURISM COUNCIL

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ

# ТАНИЛЦУУЛГА

Нисэх онгоцны буудалд зориулсан энэхүү удирдамжийг Олон Улсын Нисэх буудлуудын Зөвлөл (Airport Council International - ACI)-ийн бэлтгэсэн (хариуцлагатайгаар нисэх буудлуудыг дахин нээх) зөвлөмжид тулгуурлан боловсруулсан болно.

Дараах аргачлалууд нь “Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (ICAO)”-аас нисэхийн салбарт зориулан боловсруулсан “Нислэг: Ковид19 Нийгмийн эрүүл мэндийн хямралын үед агаарын аяллын зааварчилгаа” зөвлөмжид нийцэнийг дуулгахад таатай байна. Мөн ДЭМБ зэрэг хүлээн зөвшөөрөгдсөн бусад байгууллагын зөвлөмж, зааварчилгаатай уялдуулан боловсрууллаа. Бидний зорилго зорчигчдын хүсэн, хүлээж буй эрүүл мэнд, аюулгүй байдалд илүү анхаарал хандуулсан удирдамжийг холбогдох бүх үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байхад оршино.

Тодорхойлсон арга хэмжээ нь өндөр эрсдэлтэй нөхцөл байдал, халдвар дамжих хэсгүүдэд үндэслэсэн болохыг тэмдэглэх нь чухал юм. Тиймээс улс орон бүр өөрийн дотоодын эрсдлийн үнэлгээний түвшинд тохируулан өөрчлөлтийг оруулахыг зөвлөж байна. Учир нь зарим аргачлал нь эрсдэлийн хэмжээ багатай газруудад шаардлагагүй байж болох юм. Үүнээс гадна аргачлал дээр тулгуурлан журам батлахдаа өөрийн нисэх буудлын хэмжээ, ачаалал, багтаамжийг тооцох хэрэгтэй. Мөн авсан арга хэмжээ, тогтоосон журмыг тогтмол хугацаанд дахин нягталж үзэх шаардлагатай. Эрсдэл буурах тусам дагаж арга хэмжээг сулруулах нь үр дүнтэй. Тиймээс цаашид илүү үр дүнтэй, тохиромжтой, хэрэгжүүлэхэд хүндрэл багатай, шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээ авах ба үүнийг даруй хэрэгжүүлж, өмнө авч байсан арга хэмжээг хүчингүй болгох хэрэгтэй.

Цаашид вирусийн талаарх мэдээлэл нэмэгдэхийн хэрээр эдгээр удирдамж нь өөрчлөгдөн сайжирна. Эдгээр удирдамжийг нисэх буудлууд өөрсдийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн бүх нисэх буудал хууль болон тухайн орон нутагт дагаж, мөрдөж буй шаардлага, ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг дагаж мөрдөх хэрэгтэй.

COVID-19 цар тахлын дараах аялал жуулчлалын салбарын хамгийн эхний бөгөөд чухал алхам бол зорчигчдад аюулгүй гэдгийг мэдрүүлэх явдал юм. Иймд зорчигчдын аюулгүй байдлыг хангах ямар арга хэмжээ, удирдамж хэрэгжүүлж байгаа тухай энгийн, ил тод байдлаар зорчигчдад мэдээлэх хэрэгтэй. Аяллын туршид эрүүл мэнд, ариун цэврийн хамгийн өндөр стандартаар зорчигдод үйлчлэхэд нисэх буудлууд болон авиа компаниуд гол анхаарлаа төвлөрүүлж ажиллах нь зүйтэй.

Энэхүү удирдамжийг боловсруулахдаа зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан бөгөөд дараах асуудлыг авч үзнэ. Үүнд:

1. Нисэх буудалд зорчигчийн биеийн байдал болон халууныг хэмжих системийг нэвтрүүлэх;
2. Ариун цэвэр, халдваргүйтгэлийн арга хэмжээг ялангуяа бүртгэлийн хэсэг болон онгоцонд суух хэсгүүдэд нэмэгдүүлэх;
3. Хөл, хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд зорчигчдод зориулсан ариутгагч бодис байршуулах;
4. Бүх хүрэлцэх цэгүүдэд гар болон биеэр хүрэлцэх нөхцлийг багасгах, хязгаарлах;
5. Эрсдлийн үнэлгээгээр шаардлагатай гэж тогтоогдсон хугацаанд ажилтнууд болон зорчигчдод амны хаалт зүүх шаардлага тавих;

6. Зорчигч болон ажилтнуудын хоорондын шууд харилцааг боломжит хэмжээгээр багасгаж, өөртөө үйлчлэх паспортын цэг, төлбөрийн аргачлалыг нэвтрүүлэх;
7. Угтах, зочлох, мэдээллийн ажилтнуудыг хангалттай мэдээлэл болон сургалтаар бүрэн хангах.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй бүхий л этгээдэд илүү хялбар болгохын тулд удирдамжийг дараах 4 бүлэгт хуваасан. Үүнд:

1. **Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Зорчигчдын итгэлийг сэргээх**
4. **Урамшууллын бодлого хэрэгжүүлэх**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЖИЛТНУУДЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

**Нисэх онгоцны буудал “шинэ хэвийн байдал”-д үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Юуны түрүүнд үйл ажиллагаагаар хэвийн явуулж, амжилтттай ажиллах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажилтнуудаа бэлтгэсэн байх шаардлагатай.**

- Дараах нөхцлүүдийг хангаснаар нисэх онгоцны буудлын үйл ажиллагаагаа дахин эхлүүлэх:
  - Үйл ажиллагаагаа дахин сэргээхэд шаардагдах бүх зөвшөөрөл, лиценз авсан байх, хилийн хязгаарлалттай холбоотойгоор орон нутгийн засаг захиргаанаас багийн гишүүдэд тусгайлсан зөвшөөрөл шаардлагатай байж болохыг анхаарах;
  - Ковид19 цар тахлын халдвараас урдчилан сэргийлэх арга хэмжээ /хяналтын хуудас, тусгай ариутгал, цэвэрлэгээ г.м зүйлсийг багтаасан/-ний цогц төлөвлөгөө боловсруулах;
  - Үйл ажиллагаагаар явуулж эхлэх цагийн хуваарийг урьдчилан бэлдэх;
  - Үйл ажиллагаагаар дахин эхлэхэд шаардагдах хангалттай ажилтантай байх;
  - Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийг боловсруулах. Үндэсний хэмжээнд мөрдөж буй зохицуулалтын дагуу ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах заалт оруулах, Хэрэв ийм шаардлага байхгүй бол нисэх буудлаас эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу шинж тэмдэгтэй эсвэл өндөр халуурсан ажилтныг гэртээ байх заавар боловсруулж, мэдээлэх;
  - Одоо ашиглаж буй техник технологид шинэчлэлт хийх, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх, ашиглах боломжуудыг судалсан байх. Үүнд зайнаас төлбөр хийх, биометрийн танилт зэрэг технологи багтаж болно. Мөн зорчигч өөрөө өөрийгөө шалган нэвтрүүлэх бөгөөд ачаа өгөх, гэртээ хэвлэсэн ачааны шошго, нисэх буудлын гадна бүртгэл хийх, онгоцонд суух тасалбарыг автоматаар уншдаг хаалга, биометрийн е-хаалга гэх мэт зорчигчдын зайнаас харьцах нөхцлийг бүрдүүлэх үйл явцыг авч үзэх;

- Ресторан, кофе шоп, цайны газар зэрэгт хүнсний аюулгүй байдалтай холбоотой хангамжийн сүлжээний хяналт, хоол, хүнс боловсруулах, бэлтгэх, эрүүл ахуй, ариун цэвэр, халдваргүйтгэл, автоматжуулалт, дараалын менежментийн асуудлаар үндэсний хууль, тогтоомжид нийсэн дүрэм, заавар тогтоож, хэрэгжүүлдэг байх;
- Авиа компаниуд, түрээслэгч, тээврийн компани зэрэг хамтран ажилладаг байгууллагууд ижил төстэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарах;
- Терминал, хаалга, дэлгүүр, хүлээлгийн танхим, лоунж зэрэг тодорхой орон зайд байрлах зорчигчдын тоонд хяналт тавих, орон нутгийн хууль тогтоомжийн дагуу хүлээлгийн танхимын суудлыг дахин зохион байгуулах, блоклох, багасгах арга хэмжээ авах;
- Засгийн газар болон олон улсын эрүүл мэндийн байгууллагуудаас санал болгож буй цахим худалдан авалт зэрэг ариун цэвэр, халдваргүйтгэлийн технологийн шинэчлэлтийг нэвтрүүлэх боломжийг судлах, шилдэг туршлагыг хуваалцах;
- Эрсдлийн үнэлгээнд үндэслэн өөрийн ажилтнууд болон хамтран ажилладаг байгууллагын ажилтнуудыг хамгаалалтын халхавч болон амны хаалт, бээлий гэх мэт хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ)-ээр хангах. Мөн эрсдэлийн хэмжээнээс хамаарсан хүн хоорондын зай барих шаардлагыг биелүүлэх.

• Нисэх онгоцны буудал үйл ажиллагаандаа зориулан ажилтнуудыг дараах байдлаар бэлтгэн сургасан байна:

- Үйл ажиллагаа дахин эхлэхтэй холбогдуулан ажилтнуудад зориулсан дотоод заавар, ёс зүйн дүрэм, ажилтнуудын зан төлвийн болон үйл ажиллагааны зааварчилгаа бэлдсэн байх;
- Халдварыг хянах, хүн хоорондын зай барих, гараа тогтмол угаах, маск, бээлий хэрэглэх тухай үндэсний хууль тогтоомж, түүнчлэн илүү нарийвчилсан арга хэмжээ авах талаар буудлын дотоод журам байгаа бол эдгээр сэдвээр ажилтнуудаа давтан сургах;
- Бүх сургалтад ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх;
- Агаарын тээврийн компани, түрээслэгч, тээврийн компани зэрэг хамтран ажилладаг байгууллагуудад ижил төстэй сэдвээр ажилтнуудаа сургах талаар хүсэлт тавих;
- Ажилтнуудын эрүүл мэндэд байнгын анхаарал хяналт тавьж, тэдний Засгийн газар болон ДЭМБ-ын заавар зөвлөмжийг даган мөрдөхөд нь урамшуулан, манлайлж ажиллах;
- Нисэх буудлын эрүүл мэндтэй холбоотой шинэ арга хэмжээний зардлыг төр хариуцах;
- Ажилтнуудын сэтгэл зүй, стресс зэрэг асуудалд дэмжлэг үзүүлдэг хөтөлбөртэй байх.





# 2.ХАРИУЦЛАГАТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

**Нисэх онгоцны буудлууд ил тод байдал, харилцаа, мэдээллээр дамжуулан зорчигчдын итгэлцэл, итгэлийг сэргээх чиглэлээр ажиллахдаа дараах арга хэмжээ авсан байна. Үүнд:**

- Эрчимжүүлсэн ариутгал, халдваргүйтгэл, гүн цэвэрлэгээний арга хэмжээг ойр давтамжтай хийхэд чиглэсэн дүрэм, арга хэмжээ боловсруулсан байна:
  - Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
  - Өөртөө үйлчлэх тоног төхөөрөмж, ачаа тээшний тэргэнцэр, лангуу, ачааны тэрэг, аюулгүй байдлын хяналтын цэг, угаалгын өрөө, цахилгаан шат, шатны бариул, онгоцонд суух талбай, нийтийн эзэмшлийн талбайд ялангуяа гар болон биеэр хамгийн их хүрэлцэх хэсгүүдийг цэвэрлэхэд онцгой анхаарал хандуулсан нисэх буудлын бүх хэсэгт цэвэрлэгээ хийх зааварчилгааг шинэчлэх;
  - Онцын шаардлагагүй эд зүйлсийг нисэх онгоцны буудлаас зайчлах;
  - Агааржуулалт болон агаар шүүлтүүрийн системд хамаарах журмыг үнэлэх, халдвар тархах эрсдэлийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх;
  - Хог хаягдал зайлуулах давтамжийг нэмэгдүүлэх;
  - Цахилгаан шатаар зорчих удирдамжийг зорчигчдод мэдээлэх;
  - Нисэх буудлын хөдөлгөөн ихтэй хэсэгт хэрэглэхийг зөвшөөрсөн спиртэн суурьтай гар ариутгагчийг зорчигчдод зориулан бэлэн байлгах. зорчигч, жуулчдад зориулж ариутгалын нэмэлт бүтээгдэхүүнийг өгөх эсвэл худалдан авах боломжтой болгох.
- Шаардлагатай тохиолдолд зорчигчдын эрүүл мэндийн байдал, хувийн мэдээллийг шалгах арга хэмжээг нэвтрүүлэх, эмнэлгийн нотолгоо гаргах:
  - Засгийн газрын байгууллагуудын цахим хэрэгслээр дамжуулан онгоцонд суухаас өмнө эрүүл мэндийн эрсдлийг үнэлэх журмыг авч үзсэн байх; онгоцноос буухад саатал гарахгүй байх зорилгоор энэхүү арга хэмжээг Засгийн газруудд харилцан хүлээн зөвшөөрсөн байх;
  - Засгийн газрын зүгээс зорчигчдыг Ковид19 шинжилгээнд шууд хамруулах, ингэхдээ зорчигчдын эрхэнд халдахгүй байдлаар түргэн шуурхай зохион байгуулах, тухайн зорчигч нисэж болох үгүй эсэхийг авиа компаниудад мэдээлэх;
  - Орц, гарцад зайлшгүй шалгалт хийх тохиолдолд зайнаас харьцах байдлаар хийх, жишээлбэл бүтэн биеийн хэт улаан туяаны сканер, хэт улаан туяаны гар термометр, чихний термометр гэх мэт төхөөрөмж ашиглах. Улс хоорондоо ижил төстэй аргачлалтай байх;
  - Эрх бүхий байгууллагаас зорчигчдыг гараар нэгжих, нүүр тулан шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг багасгасан журмыг орон нутгийн хууль тогтоомжид

нийцүүлэн өөрчлөх; зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс дотоодын хууль тогтоомжийг салбар дагаж мөрдөх үүрэгтэй.
  - Биеэр хүрэх, дараалж зогсох зэрэг нөхцлийг бууруулж ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, зарлал өгөх.

- Ресторанд хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн дараах шаардлагыг хангасан байх:
  - Буфетийн хэсэгт зочдыг өөрсдөөр нь хүнсэнд хүргүүлэхгүй байх;
  - Цай, кофены машиныг тогтмол цэвэрлэх, боломжтой бол үйлчлэгч ажиллуулах;
  - Зочдыг гармагц ширээг ариутган нэн даруй цэвэрлэх;
  - Ширээ, зочдын суудал хоорондын зайн дүрмийг баримтлах;
  - Зочдын ширээн дээр тавих эд зүйлсийн тоог багасгаж, боломжтой бол багцалж, ариутгасан хэрэгсэл ашиглах.

# 3.ЗОРЧИГЧДЫН ИТГЭЛИЙГ СЭРГЭЭХ

**Зорчигчдын итгэлийг сэргээхийн тулд үйлчилгээний ил тод байдал, найрсаг харилцаанд тулгуурлан дараах арга хэмжээ авна. Үүнд:**

- Байгууллагын дижитал болон шууд сувгийг ашиглан эрүүл мэнд/эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод байдлаар тогтмол хүргэх. Зочидтой байнга харьцдаг зочлох, угтах үйлчилгээний ажилтнуудыг эрүүл мэндийн холбоотой асуултад хариулах чадвартай болгон сургаж бэлтгэх;
- Нисэх буудлын өнцөг булан бүрд эрчимжүүлсэн цэвэрлэгээний талаар ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээг зорчигчдод харагдахаар байрлуулсан байх;
- Орон нутгийн иргэд, байгууллагатай харилцаа холбоотой ажиллаж мөн тэднээс ирж болзошгүй сөрөг хандлагад бэлтгэлтэй байх;
- Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу амны хаалт зүүх, гарын ариун цэврийг сахих зэрэг мэдээллийг агуулсан зорчигчдын ёс зүйн дүрмийг зорчигчдод тогтмол мэдээлж байх;
- Төрийн байгууллагуудтай хамтран хавьтлыг мөшгөх аппликейшн ашиглах.

# 4.УРАМШУУЛЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Нисэх онгоцны буудал эргэж сэргэхэд Засгийн газрын дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Иймээс салбарынхан Засгийн газарт дараах асуудлаар хүсэлт тавих хэрэгтэй:**

- Виз олголтын үйл явцыг хялбаршуулж бас хямдруулах замаар виз олголтыг нэмэгдүүлэх
- Аялал жуулчлалын салбарт эрэлтийг өдөөх зорилгоор татвар, төлбөр, хураамжийг бууруулах замаар санхүүгийн туслалцаа үзүүлэх;
- Аялал жуулчлалын эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор урамшууллыг бий болгох, татварын хөнгөлөлт үзүүлэхээс гадна шууд дэмжлэг үзүүлэх;
- Аялал жуулчлалын дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зорин очих газрын сурталчилгааг сайжруулах;
- Хил дамнасан аяллын шинэ дүрмийг боловсруулахдаа салбарын болон засгийн газрын бусад байгууллагуудтай хамтран ажиллах.




# ХУРАЛ, ЦУГЛААН, АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

WORLD TRAVEL & TOURISM COUNCIL

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ



# ТАНИЛЦУУЛГА

Хурал, цуглаан, арга хэмжээ зохион байгуулах салбарын гол зорилго нь хүн хүч, бүтээгдэхүүн, мэдээллийн солилцоог дэмжиж, энэ нь эргээд орон нутаг, бүс нутаг, олон улсын түвшинд үнэ цэнийг бий болгоход чиглэгддэг. Гэвч одоогийн нөхцөл байдалд салбарын үнэ цэнийг хадгалахын тулд эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн чухалд үзэх шаардлагатай байгаа юм.

Хурал, цуглаан, арга хэмжээ зохион байгуулах салбарт зориулсан дараах удирдамжийг дэлхийн тэргүүлэх байгууллагуудын зөвлөмж болон тэдгээрийн олон нийтэд нээлттэй мэдээлсэн аялал жуулчлалын үйл ажиллагааг эрүүл, хариуцлагатай буцаан үргэлжлүүлэх төлөвлөгөөнөөс нэгтгэн боловсруулсан юм. Энэ баримт бичгийн гол зорилго нь хурал цуглаанд оролцогчид болон түүнийг зохион байгуулагчдын зайнаас харьцах нөхцлийг дэмжсэн, эрүүл мэнд, эрүүл ахуйн асуудалд илүү төвлөрсөн холбогдох бүх чиг үүргийн удирдамжийг бий болгоход оршино.

Вирусийн талаарх мэдээлэл нэмэгдэхийн хирээр эдгээр удирдамж нь өөрчлөгдөх, цаашид улам сайжрах юм. Хурал цуглаан, арга хэмжээ зохион байгуулдаг газар бүр өөрийн гэсэн онцлог нөхцөл байдалтай тул эдгээр удирдамжийг хэрэгжүүлэхийн өмнө тэдэнтэй зөвлөлдөх хэрэгтэй. Мөн авсан арга хэмжээ, тогтоосон журмыг тогтмол хугацаанд дахин нягталж үзэх шаардлагатай. Эрсдэл буурах тусам дагаж арга хэмжээг сулруулах нь үр дүнтэй. Тиймээс цаашид илүү үр дүнтэй, тохиромжтой, хэрэгжүүлэхэд хүндрэл багатай, шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээ авах боломжтой  байх нь чухал байна.

Аялал жуулчллын салбар Ковид19 хямралаас гарах хамгийн эхний бөгөөд чухал алхам бол хурал, цуглаан, арга хэмжэээд оролцогчид өөрсдийгөө аюулгүй гэдэгтээ итгэлтэй байх явдал юм. Иймээс тэдний аюулгүй байдлыг хангах ямар арга хэмжээ, журам хэрэгжүүлж байгаагаа энгийн, ил тод байдлаар оролцогчдод мэдээлэх хэрэгтэй.

Энэхүү удирдамжийг эрсдэлд суурилсан хандлагаар боловсруулсан бөгөөд эрүүл мэндийн үнэлгээ, үзлэг, хоолны үйлчилгээ, гар ариутгагчийн бэлэн байдал гэх мэт бүх нийтийн эрүүл мэнд, эрүүл ахуйн сайжруулсан арга хэмжээ, хүн хоорондын зай барих дүрэм, дараалал, бөөгнөрөл үүсэхээс зайлсхийх зорилгоор хугацааг дахин үнэлж,  байрны багтаамжийг зохих хэмжээгээр бууруулах болон онлайнаар хурал цуглаанд оролцох боломжийг бүрдүүлэх зэрэг асуудлыг зохих ёсоор тусгасан байна.

Хурлын турш эрүүл мэнд, ариун цэвэр, ариутгалын хамгийн өндөр стандартаар оролцогчдод үйлчлэхэд хурал зохион байгуулагчид болон хурлын танхимын эзэмшигчид гол анхаарлаа төвлөрүүлж ажиллах нь зүйтэй бөгөөд байх хэрэгтэй.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй бүхий л этгээдэд илүү хялбар болгохын тулд удирдамжийг дараах 4 бүлэгт хуваасан. Үүнд:

1. **Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Оролцогчдын итгэлийг сэргээх**
4. **Урамшууллын бодлого хэрэгжүүлэх**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЖИЛТНУУДЫН БЭЛЭН БАЙДАЛ

**Хурал, цуглаан, арга хэмжээ зохион байгуулах салбарыг дахин эхлүүлэхдээ "шинэ хэвийн" байдлаар үйл ажиллагаагаа хэвийн явуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд бэлтгэгдсэн ажилтнуудтай байх шаардлагатай.**

- Дараах нөхцлүүдийг хангасан хурал, цуглаан, арга хэмжээ зохион байгуулах салбарыг дахин эхлүүлэх боломжтой:
    - Засгийн газраас үйл ажиллагаагаа явуулах, сэргээхэд шаардлагатай бүх зөвшөөрөл, лиценз авсан байх;
    - Ковид19 цар тахлын халдвараас сэргийлэх арга хэмжээ / хяналтын хуудас, тусгай цэвэрлэгээ, ариутгалын төлөвлөгөөг багтаасан цар тахлаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах;
    - Онгоцны буудал, хөтөч, тээврийн компани зэрэг түнш байгууллагуудтай ижил төстэй арга хэмжээ авч оролцогчдын эрүүл мэндийг хамгаалах тухай тохиролцсон байх;
    - Оффист хүн хоорондын зайг баримталсан өөрчлөлт хийх, амрах өрөөнүүдэд нэг дор байх ажилтнуудын тоог хязгаарлах; халдвар тархах эрсдэлийг бууруулах зорилгоор ажлын байранд байх хүний тоог цөөрүүлж, гэрээр ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
    - Хурлын байрны суудал, ерөнхий зохион байгуулалтын зураг болон зурган мэдээллийг бэлэн байлгах;
    - Ажилтнуудын эрүүл мэндэд зориулсан дотоод журам, зааварчилгаатай байх, үндэсний хууль тогтоомжийн шаардлагын хүрээнд эрүүл мэндийн үзлэгт хамруулах. Хэрэв ийм шаардлага байхгүй бол ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу Ковид19-ийн шинж тэмдэгтэй болон өндөр халуунтай ажилтнуудыг гэрээр ажиллуулах, амраах журамтай байх;
    - Зай барих, ялангуяа дараалах хэсэгт үйлчлүүлэгч болон ажилтнуудад ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээг байрлуулах;
    - Одоо ашиглаж буй техник технологид үнэлгээ хийх, шаардлагатай бол зайнаас төлбөр хийх, онлайн бүртгэлийн орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх хувилбаруудыг судалсан байх;
    - Техник технологи ашиглан хурлын бүхий л боломжтой хэсгүүдийг онлайн эсвэл дижитал аргаар явуулах;
    - ДЭМБ, Засгийн газрын байгууллагууд, шинжээчийн байгууллагуудаас санал болгож буй цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх боломжийг судалж, шилдэг туршлагыг хуваалцах;

- Ресторан, кофе шоп, хоолны киоск зэрэг түнш байгууллага хангамжийн сүлжээний хяналт, хоол, хүнс боловсруулах, бэлдэх, эрүүл ахуй, ариун цэвэр, автоматжуулалт, дарааллын менежмент, гүн цэвэрлэгээтэй холбоотой ижил төстэй журамтай байх, мөн ажилтнуудаа үүнд бэлдсэн байхад анхаарах;
- Эрсдлийн үнэлгээнд үндэслэн шаардлагатай бол нүүрний хаалт, маск зэрэг шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ)-ээр ажилтнуудыг хангах;
- Хурал, цуглааны арга хэмжээнд цаасан урилгаас аль болох татгалзаж цахим урилга руу шилжих;
- Агааржуулалтын системд байнгын шалгалт хийх.

• Хурал, цуглаан, арга хэмжээнд зориулан ажилтнуудаа дараах байдлаар бэлдэн сургасан байна:

- Хурал цуглаан зохион байгуулагч болон хурлын танхим эзэмшигчийн зүгээс үйл ажиллагааны болон ажилтнуудад зориулсан дотоод журам, зааварчилгаа боловсруулж, хэрэгжүүлдэг байх;
- Халдварыг хянах, хүн хоорондын зай барих, зочидтой харьцах, эрүүл ахуйг сайжруулах, гар угаах, эрүүл мэндийн байгууллагын зааварчилгааны дагуу, түүнчлэн зохион байгуулагчийн зүгээс зайлшгүй гэж тодорхойлсон бол амны хаалт, бээлийн хэрэглэх зэрэг ариун цэвэр, халдвар хамгааллын арга хэмжээний талаар шаардлагатай хэрэгслэл, мэдээллээр ажилтнуудыг хангасан байх;
- Хоол хүргэлтийн үйлчилгээний компани, хөтөч, тээврийн компани зэрэг хамтран ажилладаг байгууллагуудад ижил төстэй дүрэм, журамтай байж, ажилтнуудаа сургах талаар хүсэлт тавих;
- Бүх сургалтад ДЭМБ, нийгмийн эрүүл мэндийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх;
- Ажилтнуудын эрүүл мэндэд байнгын анхаарал хяналт тавьж тэднийг Засгийн газар болон ДЭМБ-ын заавар зөвлөмжийг даган мөрдөхөд нь урамшуулан, манлайлж ажиллах.

# 2.ХАРИУЦЛАГАТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ

**Өндөржүүлсэн ариун цэвэр, халдваргүйтгэлд тулгуурласан ажилтан болон оролцогчдын аюулгүй үйл ажиллагаа явуулахын тулд дараах нөхцлийг бүрдүүлсэн байна:**

• Эрчимжүүлсэн ариун цэвэр, халдваргүйтгэлийн арга хэмжээг өндөр давтамжтайгаар хийхээр дүрэм журам тогтоосон байна:

- Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
- Угаалгын өрөө, цахилгаан шат, хурлын болон хүлээлгийн танхим зэрэг газруудын цэвэрлэгээний журамд өөрчлөлт оруулах, үүнд гар болон биеэр хамгийн их хүрдэг хэсгүүдийг цэвэрлэхэд онцгой анхаарах. Онцын шаардлагагүй эд хэрэгслийг зайчлах;
- Цахилгаан шатаар зорчих удирдамжийг зорчигчдод мэдээлэх;
- Хурлын үед хүн хоорондын зай баримтлах, цахилгаан шатанд биеэ авч явах талаар оролцогчдод мэдээлсэн байх;
- Хөдөлгөөн ихтэй хэсэгт хэрэглэхийг зөвшөөрсөн спиртэн суурьтай болон гипохлорын хүчил бүхий гар ариутгагч бэлэн байлгах. Ариутгалын нэмэлт бүтээгдэхүүнийг өгөх эсвэл худалдан авах боломжтой болгох;
- Хог хаягдлыг зайлуулах давтамжийг нэмэгдүүлэх.




- Боломжтой бол Засгийн газраас өгсөн удирдамжийн дагуу суудлын хуваарилалт хийх, бүхээг, хонгилд цуглах тоо зэргийг тогтоож, ойлгомжтой зурган мэдээллээр харуулах.
- Тухайн улсын хууль тогтоомжийн дагуу нийт оролцогчдын тоонд хязгаарлалт тогтоох. Ингэхдээ хурал, цуглаан, арга хэмжээ явуулж буй газрын өөр өөр хэсэгт эрсдлийн өөр өөр түвшинд тохирсон арга хэмжээ авах.
- Оролцогчдын мэдээлэл авах болон хоорондын зай баримтлах арга хэмжээг нэвтрүүлсэн байх:
  - Оролцогчдыг ирэхээс өмнө эрсдэлийн үнэлгээний асуулгыг бөглүүлэх;
  - Хууль тогтоомжид заасны дагуу оролцогчдын эрүүл мэнд/ температурын хяналтыг хэрэгжүүлдэг байх;
  - Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бол хүлээн авах, биеэр хүрэх бүртгэлийн хэсэгт дугаарлах нөхцлийг бууруулах;
  - Үйл ажиллагаанд оролцох бүх ажилтнуудыг бүртгэн зохион байгуулалтыг сайжруулах;
  - Хууль тогтоомжид заасны дагуу шаардлагатай бол маск хэрэглэхийг зөвлөх;
  - Ковид19-ийн шинж тэмдэгтэй байж болзошгүй оролцогчийг тусгаарлах өрөөг байгууламжийн гадна талд бэлдсэн байх.
- Хоол, хүнсний аюулгүй байдлыг хангасан байх:
  - Буфет хэсэгт зочдыг өөрсдөөр нь хүнсэнд хүргүүлэхгүй байх;
  - Цай, кофены машиныг тогтмол цэвэрлэх;
  - Оролцогчдод зориулан ус болон уух зүйлстэй холбогдуулан санамж бэлдэх. Хэрэв танхим ус цэвэршүүлэгчтэй бол аль болох зочдыг өөрсдийн усны савтай ирэхийг уриалах;
  - Ширээ, сандал болон зочдын хүрсэн хэсгүүдэд зочдыг гармагц нэн даруй цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх;
  - Суудал хоорондын зайн шаардлагыг чанд мөрдөх;
  - Зочдын ширээн дээр тавигдах зүйлсийн тоог багасгаж боломжтой бол багцалж, ариутгасан хэрэгсэл ашиглах;
  - Гаднаас хоол хүнс оруулж буй тохиолдолд түүнийг зохицуулах журамтай байх.

# 3.ОРОЛЦОГЧДЫН ИТГЭЛИЙГ СЭРГЭЭХ

**Ил тод байдал, зочидтойгоо харилцах замаар итгэл, итгэлцлийг сэргээхийн тулд дараах зүйлс дээр анхаарна. Үүнд:**

- Байгууллагын дижитал болон шууд сувгуудыг ашиглан эрүүл мэнд/эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод, байнга хүргэж байх. Зочидтой байнга харьцдаг зочлох, угтах үйлчилгээний ажилтнуудыг эрүүл мэндийн холбоотой асуултад хариулах чадвартай болгон сургаж бэлтгэх;
- Эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу маск зүүх, гарын ариун цэвэр сахих, хүн хоорондын зай барих шаардлага зэрэг оролцогчдын дагаж мөрдөх журмыг цахим шуудангаар урьдчилан явуулсан байх бөгөөд хуралд оролцох үед дахин сануулах. Мөн хурлын танхим эзэмшигчийн зүгээс болон зохион байгуулагчийн мөрдөх журмыг танилцуулах, байршлын зохион байгуулалтын зураг өгөх;
- Хурлын танхимд эрчимжүүлсэн цэвэрлэгээ, зай барих зэрэг асуудлаар ойлгоцтой тэмдэг тэмдэглэгээг оролцогчдод харагдахаар байрлуулсан байх;
- Хөдөлгөөний нягтрал ихтэй хэсэгт хэрэглэхийг зөвшөөрсөн спиртэн суурьтай гар ариутгагчийг бэлэн байлгах. Ариутгалын нэмэлт бүтээгдэхүүнийг өгөх эсвэл худалдан авах боломжтой болгох;
- Ямар нэгэн санаа зовоосон асуудал эсвэл асуулт байгаа бол оролцогч хэзээ ч асуух боломжтой гэдгийг мэдрүүлэх. Мөн оролцогчидтой харьцаж буй ажилтнуудыг асуултад хариулах, асуудлыг шийдэх чадвартай болгон бэлтгэн сургах;
- Даатгалын компаниудтай харилцаа тогтоон боломжтой бол Covid-19 цар тахлыг хамарсан даатгалыг судалсан байх;
- Биеэр оролцох боломжгүй оролцогчдод зориулан цахим платформ ашиглан хурал, цуглаан зохион байгуулах боломжийг судлах;
- Байгууламжид эмнэлгийн үйлчилгээний цэгийг байгуулах, COVID-19 илэрсэн тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх боломжтой байх.

# 4.УРАМШУУЛЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Хурал, цуглаан, арга хэмжээ эргэж сэргэхэд Засгийн газрын зүгээс бодлогын дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Салбарынхан Засгийн газарт дараах хүсэлт тавих хэрэгтэй:**

- Хил дамнасан аяллын болон ачаа тээврийн шинэ дүрмийг боловсруулахдаа салбарын, гурав дах талын болон бусад орны засгийн газруудтай хамтран ажиллах;
- Эрэлтийг өдөөх зорилгоор татвар, төлбөр, хураамжийг бууруулах замаар салбарт санхүүгийн туслалцаа үзүүлэх;
- татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх урамшууллыг бий болгох, шууд дэмжлэг үзүүлэх;
- Аялал жуулчлалын дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зорин очих газрын сурталчилгааг сайжруулах.

# COVID-19 ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨГӨӨ, ЗӨВЛӨМЖ




СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГАД
ӨГӨХ ЗӨВЛӨМЖ
КОРОНАВИРУСТ КОВИД-19 ХАЛДВАРААС СЭРГИЙЛЬЕ!
ЦУВРАЛ №10
Байгууллагад:
БИЕИЙН ХАЛУУН ҮЗЭХ
АМНЫ БОЛОН НҮҮРНИЙ ХААЛТ ЗҮҮХ
СПИРТЭН СУУРЬТАЙ ГАР ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭГЧ БАЙРШУУЛАХ
ГАР УГААХ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ, ГАРЫН ЦААС, САВАН БАЙЛГАХ
ҮЗЭГЧДИЙГ СУУДАЛ АЛГАСАЖ СУУЛГАХ
АГААРЖУУЛАГЧ АЖИЛЛУУЛАХ, АГААР СЭЛГЭЛТ ТОГТМОЛ ХИЙХ
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАХДАА НЭГ УДААГИЙН БЭЭЛИЙ ӨМСӨХ
БЭЛЭН МӨНГӨӨР АЛЬ БОЛОХ ҮЙЛЧЛЭХГҮЙ БАЙХ
БИЛЕТИЙН КАСС, ХУДАЛДААНЫ ЦЭГ, ХҮЛЭЭЛГИЙН ӨРӨӨНД ЗАЙ БАРИХ ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙХ
ТАСАЛБАРЫГ ЦАХИМААР АВАХ БОЛОМЖ БҮРДҮҮЛЭХ
ҮЗВЭР ҮЙЛЧИЛГЭЭ ХООРОНД ТАНХИМЫГ ТОГТМОЛ ЦЭВЭРЛЭЖ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ
1Л УСАНД 25МЛ БЕЛИЗНА ХИЙЖ ШИРЭЭ, САНДАЛ, ТАВЦАН, ХААЛГАНЫ БАРИУЛ, ШАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ЗЭРЭГ ХАТУУ ГАДАРГУУГ АРЧИЖ ЦЭВЭРЛЭХ
МИКРОФОНД НЭГ УДААГИЙН УУТ ХИЙХ
ХООЛНЫ ГАЗАР, АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨГ ТОГТМОЛ ЦЭВЭРЛЭЖ, 1 ЛИТР УСАНД 25МЛ БЕЛИЗНА (ХЛОР АГУУЛСАН БОДИС) ХИЙСЭН УУСМАЛААР ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ
АВТОМАТ ТОГЛООМЫН ГАЗРЫГ САЙТАР ЦЭВЭРЛЭЖ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ
ХУВИЙН ЭД ЗҮЙЛСЭЭ БУСАДТАЙ СОЛИХГҮЙ БАЙХ
ХҮЛЭЭЛГИЙН ТАНХИМД ХҮНИЙ БӨӨГНӨРӨЛ ҮҮСГЭХГҮЙ БАЙХ
КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖИЙГ ИЛ ТОД БАЙРШУУЛАХ
ХАЛУУРАХ, ХАНИАХ, ЦЭЭЖЭЭР ӨВДӨХ ЗЭРЭГ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ 119, 80086829 ДУГААРТ ХАНДАХ
Үйлчлүүлэгчдэд:
АМНЫ ХААЛТ ЗҮҮХ
ХҮН ХООРОНДЫН ЗАЙ БАРИХ
ГАРАА САВАНДАЖ УГААХ, СПИРТЭН СУУРЬТАЙ ГАР ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭГЧ ХЭРЭГЛЭХ
НҮД, АМ, ХАМАРТАА ХҮРЭХГҮЙ БАЙХ
ЦАХИМААР ТАСАЛБАР ХУДАЛДАН АВАХ
БЭЛЭН МӨНГӨӨР АЛЬ БОЛОХ ТООЦОО ХИЙХГҮЙ БАЙХ
ХООЛ УНД ХУВААХГҮЙ ТУС ТУСДАА ИДЭХ


ЗОЧИД БУУДАЛД
ӨГӨХ ЗӨВЛӨМЖ
КОРОНАВИРУСТ КОВИД-19
ХАЛДВАРААС СЭРГИЙЛЬЕ!
ЦУВРАЛ №12
Аж ахуй нэгжид:
ЗОЧИД БУУДАЛД БАЙГАА ИРГЭН, АЖИЛЛАГСДЫН ХООЛ, ХҮНСНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНД ХЯНАЛТ ТАВЬЖ, ЧАНАРТАЙ, АЮУЛГҮЙ ХООЛ, ХҮНСЭЭР ХАНГАН, БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙХЭЭ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАРИУЦНА.
УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭГДСЭН, ХАЯГ ШОШГЫН ЗӨРЧИЛГҮЙ, ХЭРЭГЛЭХ ЗААВАР ТОДОРХОЙ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫГ НИЙЛҮҮЛЖ, БАТЛАГДСАН ЗААВРЫН ДАГУУ ХЭРЭГЛЭЖ БАЙГАА ЭСЭХЭД ДОТООДЫН ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАНА.
ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ДЭГЛЭМИЙГ ЧАНД БАРИМТЛАН УГААЛГА, ЦЭВЭРЛЭГЭЭГ ТОГТМОЛ ХИЙЛГЭЖ, ХОГ ХАЯГДЛЫГ ТОГТМОЛ ЗАЙЛУУЛНА.
ЗОЧИД БУУДЛЫН БАЙРНЫ НИЙТ ОРНЫ ТОО, БАЙРШЛЫГ БАРИЛГЫН ДАВХАР, ӨРӨӨНИЙ ДУГААРААР ЗУРАГЛАЛ ГАРГАСАН БАЙНА.
ЗОЧИД БУУДАЛД АЖИЛЛАХ АЖИЛТНУУДЫГ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ЗОХИОН БАЙГУУЛАХ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ СУРГАЛТАД БҮРЭН ХАМРУУЛНА.
ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНТЭЙ ХАРЬЦАХ, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД БҮРЭН ХАМРАГДСАН, "ЭРҮҮЛ" ТОГООЧ, АЖИЛТНУУДЫГ АЖИЛЛУУЛНА.
ӨӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДЫГ ХУВИЙН ХАМГААЛАХ ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ, УГААЛГА ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН БОДИСООР БҮРЭН ХАНГАНА.
ӨРӨӨНИЙ ЭД ХОГШЛЫН ЖАГСААЛТЫГ ГАРГАЖ, ЭД ХОГШЛЫГ АРИГ ГАМТАЙ ХЭРЭГЛЭХ, БОЛЗОШГҮЙ АЮУЛЫН ҮЕД ГАРАХ ГАРЦ, ШАТ, ГАДНА ХААЛГА РУУ ХҮРЭХ СХЕМ, САНАМЖИЙГ ӨРӨӨ ТУС БҮРТ БАЙРЛУУЛСАН БАЙНА.
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2020 ОНЫ 4-Р САРЫН 14-НИЙ ӨДРИЙН А/249 ТООТ ТУШААЛААР БАТЛАГДСАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТЫН ТҮР ЖУРМЫГ МӨРДӨЖ АЖИЛЛАНА.
Үйлчлүүлэгч нарт:
АМНЫ ХААЛТ ТОГТМОЛ ЗҮҮХ
БУСАДТАЙ ГАР БАРИХГҮЙ, ТЭВРЭЛДЭХГҮЙ, ҮНСЭЛДЭХГҮЙ БАЙХ
НҮҮР, НҮД, АМ, ХАМАРТАА ХҮРЭХГҮЙ БАЙХ
ХҮН ХООРОНДЫН ЗАЙ БАРИХ
ХООЛ УНД ХУВААЖ ИДЭХГҮЙ БАЙХ
ГҮЙЦЭД БОЛГОСОН ХООЛ ХҮНС ХЭРЭГЛЭХ
ТАМХИ ДАМЖУУЛАН ТАТАХГҮЙ БАЙХ
НЭГ ӨРӨӨНД БӨӨГНӨРӨХГҮЙ БАЙХ
ГАРАА САВАНДАЖ УГААХ, СПИРТЭН СУУРЬТАЙ ГАР ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭГЧ ХЭРЭГЛЭХ
ХЭРЭГЛЭСЭН АМНЫ ХААЛТЫГ ИЛ ЗАДГАЙ ХАЯХГҮЙ БАЙХ
ХЭРЭВ ХАЛУУРВАЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ХАНДАН ЗӨВЛӨГӨӨ АВАХ
ТУХАЙН БАЙГУУЛЛАГААС ГАРГАСАН ҮЙЛЧЛЭХ ЖУРАМ, ХУВААРИЙГ МӨРДӨН, ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ, ГАДААДЫН ИРГЭН БОЛ ПАСПОРТОО БИЕДЭЭ БАЙНГА АВЧ ЯВАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАНД ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ҮНЭН ЗӨВ ГҮЙЦЭД ӨГӨХ






# ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГУУД

WORLD
TRAVEL &
TOURISM
COUNCIL

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ



# ТАНИЛЦУУЛГА

Жижиглэн худалдааны байгууллагад санал болгож буй доорх удирдамжийг БНХАУ-д хоёр худалдааны цогцолборт үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлсэн “The Bicester Village Shopping Collection” байгууллагын боловсруулсан мэдээлэлд үндэслэн нэгтгэв . Энэхүү баримт бичгийг жижиглэн худалдааны байгууллагуудыг хариуцлагатайгаар олон нийтэд нээхэд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын зааварчилгаанд үндэслэсэн, жуулчдын хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн, эрүүл мэнд, аюулгүй байдал, хүн хоорондын зайд илүү анхаарсан холбогдох бүх чиг үүргийн нэгдсэн стандартыг бий болгох зорилгоор боловсруулсан.

Цаашид вирусын тухай мэдээлэл нэмэгдэхийн хэрээр эдгээр удирдамж нь шинэчлэгдэн, сайжрахыг анхаарна уу. Энэхүү удирдамжийг жижиглэн худалдааны үйл ажиллагааны шинж чанарт үндэслэн боловсруулсан бөгөөд хэрэгжүүлэхийн өмнө дотоодын засаг захиргаа, эрүүл мэндийн байгууллагуудтай зөвлөлдөх нь зүйтэй.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бүх хүнд илүү хялбар болгох үүднээс удирдамжийг дараах 5 үндсэн хэсэгт хуваасан болно. Үүнд:

1. **Үйл ажиллагааг дахин эхлүүлэх**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Аялагчдын итгэлийг дахин сэргээх**
4. **Инновацийг нэвтрүүлэх**
5. **Урамшууллын бодлого хэрэгжүүлэх**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДАХИН ЭХЛҮҮЛЭХ

**Дараах нөхцлийг бүрдүүлсэн жижиглэн худалдааны байгууллагууд үйл ажиллагаагаа дахин үргэлжлүүлж болно. Үүнд:**

- Засгийн газрын болон эрүүл мэндийн байгууллагын албан ёсны зааварчилгаатай уялдсан үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулсан байх;
- Хариуцлагатайгаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд шаардагдах хүний нөөцийн бэлтгэл хангагдсан байх;
- Үйл ажиллагааг дахин эхлүүлэхээс өмнө дотоодын засаг захиргааны журмаар тодорхойлсон хүн хоорондын зай барих, халуун хэмжих, зочидтой харьцах бүх ажилтнууд хамгаалалтын маск зүүх шаардлагатайг ажилтнуудад ойлгуулж, сургах;
- Уулзалтын хэсэг болон бусад цугларал үүсч болзошгүй хэсгүүдийг түр хааж, хүн хоорондын зай барих, эрүүл аюулгүй ажиллагааг дэмжсэн дахин тохижуулсан оффис болон ажлын байраар хангах;
- Боломжит бүхий л нөхцөлд оффис ажлын байранд цонх нээн цэвэр агаар оруулж, агаар цэвэршүүлэх систем ажиллуулж, агаарын тогтмол солилцоо явагдах нөхцлөөр хангах;
- Хамтын ажиллагаатай байгууллагууддаа чиглэсэн дотоодын хууль тогтоомжийн дагуу тогтоосон ажлын цаг, хүргэлтийн цаг, баглаа боодлын хаягдал, худалдаалж буй бараа бүтээгдэхүүн, тэдгээрт болгоомжтой хандаж буй байдал, хүн хоорондын зай барих, хувцас солих өрөөний тохижилт, гүн цэвэрлэгээ болон ариутгал, цаасан төлбөрийн баримтаас дижитал баримт руу шилжих зэргийг багтаасан удирдамж боловсруулсан байх;
- Хүн хоорондын зай барих шаардлагатай шинэ нөхцөл байдалтай уялдаатайгаар ажилтнуудад үйлчлүүлэгчтэй харьцах, зөвлөх чадварыг шинээр сургах;
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт (ресторант, кафе болон хоолны тэрэг) зориулж хангамжийн сүлжээний хяналт, хоол бэлтгэх, ажилтнууд хүн хоорондын зай барих, гүн цэвэрлэгээ болон сайжруулсан эрүүл ахуй, суудал, үйлчлүүлэгчдийн дарааллыг зохицуулах болон хоолны цэсийг цахимжуулах зэргийг багтаасан удирдамж, хөтөлбөр боловсруулсан байх;
- Ажлын хэсэгт (гал тогоо, ажилтнуудын амралтын хэсэг г.м) хүн хоорондын зай барих, хог хаягдлын менежмент болон гүн цэвэрлэгээг илүү тогтмолжуулж хавьталд орох бүх хүмүүсийн халууныг шалгах тусгай байрлалтай байх;
- Бэлтгэн нийлүүлэгч болон гурав дахь талуудтай удирдамжийг хэлэлцэж, уялдуулах;
- Орон нутгийн аялал жуулчлал, тээврийн түншүүдтэй холбоо барьж, зочдыг бөөгнөрүүлэхээс зайлсхийх хангалттай зай барих шаардлагыг сурталчлах.

# 2.ХАРИУЦЛАГАТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

**Жижиглэн худалдааны байгууллагууд нь зочид болоод ажилтнууддаа аюулгүй үйлчлэхийн тулд дараах нөхцлийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:**

- Ариун цэврийн болон нярайн живх солих өрөө, үйлчлүүлэгчийн хувцас сольж үзэх өрөө болон мөргөлийн өрөө гэх мэт хэсгийн цэвэрлэгээний зааварчилгаар дахин хянаж ариутгал, гүн цэвэрлэгээ, халдвар тарах эрдлийг бууруулах арга хэмжээг сайжруулах;

- Ариутгал, эрүүл ахуйн үйл ажиллагааны хүрээнд 70% спиртийн агууламжтай гар ариутгагчийг угаалгын өрөө, орох гарах хаалгын ойролцоо болон бусад цэгүүдэд тараан байрлуулах;

- Халуун хэмжих, хүн хоорондын зай барих шаардлагыг биелүүлэх, дарааллын мененжмент зэрэг үйлчлүүлэгчдийн эрүүл ахуйг хамгаалах хэм хэмжээг нэвтрүүлэх. Үүнд:
    - Халуун хэмжих ажиллагааг дадал болгох, түүнийг дэмжих дэд бүтцийг сайжруулах;
    - Дотоодын хууль тогтоомжийн дагуу хамгаалалтын маск зүүх ёстой бол байгууллага дотор энэ нь мөрдөгдөж буй эсэхэд анхаарах;
    - Хүн хоорондын зай барих тэмдэг тэмдэглэгээ байрлуулах;
    - Зай барих шаардлага мөрдөгдөх нөхцлийг бүрдүүлж, байгууллагаар үйлчлүүлж буй зочдын тоонд анхаарах;
    - Дэлгүүрээр үйлчлүүлж буй зочдын тоог хянаж, дарааллын менежментийг хэрэгжүүлж, хүн хоорондын зай барих шаардлагыг дэмжсэн бүхий л системийг хэрэгжүүлэх;
    - Бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх үүднээс машины зогсоолыг сайжруулах;
    - Зочдод нэг удаагийн хэрэглээний бээлий тараах электрон цэгүүдийг бий болгож тогтмол ариутгах.
- Байршлын схем, дарааллын менежмент, хоолны цэс, худалдан авалт, төлбөр төлөх үйл явцыг цахимжуулж, зайнаас харилцах явдлыг боломжит бүхий л нөхцөлд дэмжих. Цахим хэрэглээг дэмжиж үнэгүй wifi хангах;
- Тоглоомын талбай, ундны усан оргилуур, ATM зэрэг хүн хоорондын зай барих, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангаж чадахгүй үйлчилгээ, түүнчлэн зочдод үйлчлэх зүйлс, жишээлбэл шүхэр, тэргэнцэр зэргийг түр зогсоох.



# 3.АЯЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ ДАХИН СЭРГЭЭХ

**Жижиглэн худалдааны байгууллагууд нь үйлчлүүлэгч, бренд бүтээгдэхүүний түнш, ажилтан болоод олон нийтийн итгэлийг сэргээхдээ дараах нөхцлийг хангасан байх шаардлагатай. Үүнд:**

- Үндэсний хууль тогтоомжийн шаардлагад үндэслэн маск зүүх, гар ариутгах болон хүн хоорондын зай барих шаардлагыг багтаасан зочдын ёс зүйн дүрмийг боловсруулсан байх;
- Байгууллагын албан ёсны веб хуудас, бусад цахим сувгуудаар дамжуулан байгууллагын баримтлах дүрмийн талаар ойлгомжтой, тогтмол мэдээ мэдээлэл хүргэх;
- Мөрдөгдөх шинэ дүрмийн талаарх үйлчлүүлэгч, зочдын асуултуудад хариулахад бэлэн байж, мөн ажилтнуудыг үнэн зөв хариуцлагатай хариулт, мэдээллээр хангах;
- Гуравдагч болоод хамын ажиллагаатай байгууллага, тэдний үйлчлүүлэгчидтэй байнгын харилцаа холбоотой байх;
- Хэвлэл мэдээлэлд тогтмол, уялдаа холбоотой мэдээлэл өгөх;
- Орон нутгийн засаг захиргаа, аялал жуулчлалын байгууллага зэрэг олон нийтийн салбарын түншүүдтэй шинэ дүрмүүдийг тайлбарлаж, тэднийг шинэ дүрмийг даган мөрдөж, дэмжихийг уриалахын зэрэгцээ орон нутаг, бүс нутаг, үндэсний эдийн засгийг нөхөн сэргээх ажилд нэгдэн хамтран ажиллах.

# 4.ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭХ

- Хамгийн сайн туршлагыг нутагшуулах зрилгоор  анагаах ухаан, эрдэм шинжилгээний мэргэжилтнүүдийн боловсруулсан шинжлэх ухааны удирдамжид тулгуурлан аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг тасралтгүй хөгжүүлэх;
- Гадаа орчинд хүн хоорондын зай барих, тав тухтай худалдан авалт хийх боломж олгох дижитал үйлчилгээний шинэ технологи судлах, нэвтрүүлэх замаар сэргэлтийг хурдасгах.

# 5.УРАМШУУЛЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Жижиглэн худалдааны байгууллагын үйл ажиллагааг сэргээхэд  Засгийн газар бодлогын түвшинд дэмжлэг үзүүлэх нь нэн чухал юм. Засгийн газар дараах нөхцлийг хангах шаардлагатай байна. Үүнд:**

- Аялал жуулчлалын дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зорин очих газрын сурталчилгааг сайжруулах;
- Татвар, төлбөр, хураамжийг бууруулах замаар салбарт санхүүгийн туслалцаа үзүүлэн эрэлтийг өдөөх;;
- Аялал жуулчлалыг хөгжүүлэхийн зэрэгцээ татварын хөнгөлөлтийг бий болгох;
- Визийг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлж, визийг илүү хямд, авахад хялбар болгох;
- Нийтийн тээврийн хэрэгсэлд хүн хоорондын зай баримтлах.

# ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН НҮДЭЭР ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХЭД МӨРДӨХ ШИНЭ ДҮРМИЙГ ХАРАХ НЬ



1

**ЗОЧЛОХООС ӨМНӨХ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХОЛБОГДОХ ХАРИЛЦАА**

- Түнш байгууллага болон орон нутгийн аялал жуулчлал, тээврийн түншүүддээ шинэ удирдамжийн талаарх мэдээллийг түгээх
- Имейл, веб хуудас, аппликейшн, дижитал болон олон нийтийн сувгуудаар дамжуулан харилцах



2

**ХУДАЛДААНЫ ЦОГЦОЛБОРТ ИРЭХ ҮЕД**

- Худалдааны цэг болон тээврийн хэрэгсэл дотор хүн хоорондын зай барих
- Нэг зэрэг үйлчлүүлж болох хүмүүсийн тоог анхаарах
- Авто машины зогсоолийн менежмент хэрэгжүүлэх
- Биеийн халуун хэмжих
- Үйлчлүүлэгчийн ёс зүйн дүрмийг дагах



3

**ЗОЧДОД ЗОРИУЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ**

- Цахим чиглүүлэг хийх
- Угаалгын өрөөний гүн цэвэрлэгээ, ариутгал хийх
- Хүлээлгийн өрөөний гүн цэвэрлэгээ, ариутгал хийх
- Хүүхдийн тоглоомын талбай хаагдсан байх
- Зогсоолын ажилтан ажиллуулахгүй байх
- Дижитал үйлчилгээ: eVIP, e-HFS г.м нэвтрүүлэх

4



**ХУДАЛДААНЫ ЦОГЦОЛБОР ДОТОР**

- Гүн цэвэрлэгээ хийх
- Хүн хоорондын зай барих
- Цахим чиглүүлэг, тэмдэглэгээ тавих
- Дараалын менежмент баримтлах
- Маск зүүх
- Гарын ариун цэвэр сахих

5



**НЭРИЙН БАРААНЫ ДЭЛГҮҮР ДОТОР ҮЙЛЧЛҮҮЛЭХ**

- Дэлгүүр болоод ажилтны бэлэн байдлыг хангах
- Дэлгүүр доторх эд барааны менежментийг сайжруулах
- Хүн хоорондын зай барих
- Дараалын менежмент баримтлах
- Дэлгүүрээр нэг зэрэг үйлчлүүлж болох хүний тоог анхаарах
- Зайнаас төлбөр төлөх систем нэвтрүүлэх
- Дэлгүүрийн болоод хувцас солих өрөөг цэвэрлэх шинэ дүрэмтэй байх
- Маск зүүх
- Гарын ариун цэвэр сахих
- Дэлгүүрийн ёс зүйн дүрэм хэрэгжүүлэх

6



**РЕСТОРАН, КАФЕ, КИОСК**

- Ханган нийлүүлэх сүлжээнд хяналт тавих
- Хоол бэлтгэх явцыг хянах
- Ресторанаы дагаж мөрдөх дүрэмтэй байх
- Маск зүүх
- Гарын ариун цэвэр сахих
- Хүн хооронд зай барих (дотор болон гадаад тавцанд хамаарна)
- Гүн цэвэрлэгээ, ариутгал хийх
- Цахим хоолны цэс нэвтрүүлэх
- Дараалын менежмент баримтлах

7

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХУВИЙН ОРОН ЗАЙ**

- Урьдчилан захиалсан машин зогсоолтой байх
- Хоол үйлдвэрлэл, бэлтгэлийн хяналт тавих
- Гүн цэвэрлэгээ, ариутгал хийх
- Хүн хооронд зай барих
- Гарын ариун цэвэр сахих
- Дижитал үйлчилгээ: Цахим худалдаа, eVIP, E-HFS г.м нэвтрүүлэх



8

**СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ**



9

**АЖИЛТАН, ХУДАЛДААНЫ ЦОГЦОЛБОРТ ГАЗРУУДЫГ ДАХИН НЭЭХ**

- Багийн бэлтгэл хийх
- Олон нийтэд хүрч ажиллах
- Хүн хоорондын зай барих
- Гүн цэвэрлэгээ, ариутгал хийх
- Маск зүүх
- Гарын ариун цэвэр сахих



# COVID-19 ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨГӨӨ, ЗӨВЛӨМЖ




ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЬЕ!
ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ
Ажилчдын биеийн халууныг үзэж нэвтрүүлэх
Ажлын малгай, хувцас, гутал, улавч өмсөх
Маск, тусгай амны хаалт зүүх
Хүнтэй 1.5-2 метрийн зайнаас харьцах
Хүнс, хоол үйлдвэрлэх, худалдах зэрэг шат дамжлага бүрт спиртэн суурьтай гар ариутгагч байршуулж хэрэглэх
Нэг удаагийн бээлий хэрэглэж тайлах бүрт гараа заавал савандаж угаах
Хоол бэлтгэх өрөө, талбай, хатуу гадаргуур ахуйн хэрэглээний халдваргүйжүүлэх бодисоор 2 цаг тутам цэвэрлэх
Аяга, таваг, халбага, сэрээг ахуйн хэрэглээний халдваргүйжүүлэх бодисоор сайтар угаах
Түүхий, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнийг зориулалтын дагуу хадгалах
Хүргэлтийн үйлчилгээний ажилтан амны хаалт зүүж, бээлий өмсөх
Ажилчдад коронавируст халдварын эмнэлзүйн шинж тэмдэг, урьдчилан сэргийлэлтийн талаар мэдээлэл өгөх
Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг ил тод байршуулах
Ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах
Хоол хүнс бэлтгэх, хадгалах өрөөг шавьж мэрэгчээс хамгаалах
ХАМТДАА ДАВНА


ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
КОРОНАВИРУСИЙН
ХАЛДВАРААС СЭРГИЙЛЬЕ!
ХҮНСНИЙ ДЭЛГҮҮР, ХУДАЛДААНЫ ТӨВД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ
Өглөө бүр ажилтнуудын биеийн халуун үзэж тэмдэглэх
Хүн хоорондын зай барих, тэмдэглэгээ хийх
Лангуу, тэрэг, сагс, хаалга, хөргөгчний бариул, хүнсний хавчаар зэрэг хатуу гадаргууг 1 литр усанд 25мл белизна (хлор агуулсан бодис) хийсэн уусмалаар өдөрт 3-аас доошгүй удаа цэвэрлэж халдваргүйжүүлэх
Карт уншигч пос машиныг спиртэн суурьтай уусмалаар арчих
Жимс жимсгэнэ, цагаан идээ зэрэг шууд хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай байрлуулахгүй байх
Амталгаат худалдаа хийхгүй байх
Бээлий эсвэл хүнсний хавчаар хэрэглэн иргэдэд үйлчлэх
Сав,баглаа, боодлыг чийгтэй алчуураар арчих
Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч байршуулах
Агаар сэлгэлт тогтмол хийх
Белизнагийн уусмалаар тавцан, сандал, цахилгаан шатны бариул, шал зэрэг хатуу гадаргууг өдөрт 3-аас доошгүй удаа арчих
Ариун цэврийн өрөөнд гар угаах саван, сальфетка байрлуулах
Бие засах газрыг өдөрт 3-аас доошгүй удаа цэвэрлэж халдваргүйжүүлэх (жавелин, хлорсепт)
Хог хаягдлыг тухай бүр нь зайлуулах
ХАМТДАА ДАВНА




Safe travels by WORLD TRAVEL & TOURISM COUNCIL




# АВТОМАШИНЫ ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

WORLD TRAVEL & TOURISM COUNCIL

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ




# ТАНИЛЦУУЛГА

Автомашины түрээсийн үйлчилгээ нь ердийн болон цар тахлын үед аялагч, эрүүл мэндийн ажилтан, яаралтай тусламжийн үйлчилгээ зэрэгт онцгой ач холбогдолтой үйлчилгээ юм.

Энэхүү удирдамжийг боловсруулахдаа автомашины түрээсийн үйлчилгээ эрхэлдэг дэлхийн тэргүүлэх байгууллагуудын зөвлөмж болоод тэдгээрийн аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг хариуцлагатай дахин үргэлжлүүлэх төлөвлөгөөг нэгтгэн боловсруулсан юм. Удирдамжид Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын зааварчилгааг харгалзан үзсэн болно. Энэхүү баримт бичгийн зорилго нь зай барих, эрүүл мэнд, эрүүл ахуйн асуудалд илүү төвлөрсөн холбогдох бүх чиг үүргийн удирдамжийг бий болгоход оршино.

Вирусийн талаарх мэдээлэл нэмэгдэхийн хэрээр эдгээр удирдамж нь шинэчлэгдэн, өөрчлөгдөхийг анхаарна уу. Автомашины түрээсийн үйлчилгээ үзүүлэгч бүр эдгээр удирдамжийг өөрсдийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх нь зүйтэй. Автомашины түрээсийн үйлчилгээнд дотоодын хууль тогтоомж, ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн удирдамжийг дагаж мөрдөхийг зөвлөж байна.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй бүхий л этгээдэд илүү хялбар болгохын тулд удирдамжийг дараах 4 бүлэгт хуваасан болно. Үүнд:

1. **Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Оролцогчдын итгэлийг сэргээх**
4. **Урамшууллын бодлого хэрэгжүүлэх**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЖИЛТНУУДЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

**Автомашины түрээсийн үйлчилгээ, байгууллагууд нь үйл ажиллагаагаа “шинэ хэвийн байдал”-д дахин эхлүүлэхдээ үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд бэлтгэгдсэн ажилтнуудтай байх шаардлагатай.**

- Дараах нөхцлүүдийг хангасан автомашины түрээсийн үйл ажиллагааг дахин эхлүүлэх боломжтой:
  - Засгийн газраас үйл ажиллагаагаа явуулах, сэргээхэд шаардлагатай бүх зөвшөөрөл, лиценз авсан байх;
  - Ковид19 халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө/ шалгах хуудас боловсруулж, бүхээг, киоск, зогсоол, засварын өрөө, авто угаалга, үйлчилгээний газруудын цэвэрлэгээ, ариутгалын тусгай төлөвлөгөө гаргах;
  - Үйл ажиллагааг дахин эхлүүлэхэд шаардагдах хангалттай ажилтнуудтай байх;
  - Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн дотоод журам, зааварчилгаатай байх, үндэсний хууль тогтоомжийн шаардлагын хүрээнд автомашины түрээсийн үйлчилгээ үзүүлдэг ажилтанг эрүүл мэндийн үзлэгт хамруулах. Хэрэв шаардлагагүй гэж үзвэл нийгмийн ДЭМБ-ын зааварчилгааны дагуу халдварын шинж тэмдэгтэй эсвэл өндөр халуунтай ажилтныг гэртээ байх журам боловсруулж, мэдээлэх;
  - Орон нутгийн аялал жуулчлал, тээврийн түншүүд, мөн нисэх онгоцны буудал, автомашин угаах гэх мэт хамтран ажиллагаатай компаниудтай уялдуулсан журамтай байх;
  - Оффист болон салбар байршилд хүн хоорондын зайг баримталсан өөрчлөлт хийх, ажлын байранд болон амрах өрөөнүүдэд нэг дор байх ажилтнуудын тоог хязгаарлах;
  - Хүн хоорондын зай барих, ялангуяа ачаалал ихтэй үед дараалал үүсдэг хэсэгт үйлчлүүлэгч болон ажилтанд ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээтэй байх. Боломжтой бол бүхээгт шилэн хаалт байрлуулах;
  - Нисэх онгоцны буудалд үйлчлүүлэгчид болон ажилтнууд хоорондын харьцах цэгүүдийн тоог багасгах зорилгоор нээлттэй бүхээгний тоог багасгах;
  - Зайнаас төлбөр тооцоо, бүртгэл хийх, өөрөө өөртөө үйлчлэх боломжийг бүрдүүлэх зэрэг нэгдсэн автомат технологи нэвтрүүлэх;
  - Засгийн газрын харъяа байгууллагууд, ДЭМБ зэрэг байгууллагуудаас санал болгож буй цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх боломжийг судалж, шилдэг туршлагыг хуваалцах;



- Үйлчлүүлэгчтэй шууд харьцах шаардлагатай ажилтнуудыг маск, бээлий зэрэг хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ)-ээр хангах.

• Автомашины түрээсийн үйлчилгээ эрхлэгч ажилтнуудаа дараах байдлаар бэлтгэн сургасан байна:

  - Үйл ажиллагааны болон ажилтнуудад зориулсан дотоод журам, зааварчилгаа боловсруулж, хэрэгжүүлдэг байх;
  - Дотоодын эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж эсвэл компаниас тогтоосон илүү нарийвчилсан шаардлагын дагуу халдварыг хянах, хүн хоорондын зай барих, амны хаалт, бээлий хэрэглэх зэрэг ариун цэвэр, халдвар хамгааллын арга хэмжээний талаар ажилтнуудыг давтан сургасан байх;
  - Бүх сургалтад ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх;
  - Ажилтнуудын эрүүл мэндэд байнгын анхаарал хяналт тавьж тэднийг Засгийн газар болон ДЭМБ-ын заавар зөвлөмжийг даган мөрдөхөд нь урамшуулан, манлайлж ажиллах.

# 2.ХАРИУЦЛАГАТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ

**Өндөржүүлсэн ариун цэвэр, халдваргүйтгэлийг бататгах замаар ажилчид болон үйлчлүүлэгчдэд аюулгүй үйл ажиллагаа явуулахын тулд автомашины түрээсийн үйл ажиллагаа эрхлэгч дараах нөхцлүүдийг бүрдүүлсэн байна:**

• Эрчимжүүлсэн ариун цэвэр, ариутгал, халдваргүйтгэл, гүн цэвэрлэгээний арга хэмжээг өндөр давтамжтай хийхэд чиглэсэн дүрэм журам тогтоосон байна:

  - Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
  - Бүхээг, ширээ, компьютер, бүртгүүлэх болон гарах хэсэг, нийтийн танхим, угаалгын өрөө зэрэг газруудын цэвэрлэгээний журамд өөрчлөлт оруулах, /гар болон биеэр хамгийн их хүрдэг хэсгүүдийг цэвэрлэхэд онцгой анхаарах/. Онцын шаардлагагүй эд хэрэгслийг зайчлах;
  - Түлхүүр, жолооны хүрд, араа хөшүүрэг, суудал, суудлын халаас, хамгаалах бүс, хаалганы бариул, хурдны хайрцаг, бээлийн хайрцаг, агааржуулалтын нүх, түлхүүрийн хайрцаг, хаалганы дотор тал, суудал хоорондох хэсэг, самбар, радио залгуур, арын болон хажуу толь, аяганы тавиур болон бусад гадаргуу зэрэг байнга хүрдэг цэгүүдийн цэвэрлэгээнд онцгой анхаарсан тээврийн хэрэгслийн дотор цээвэрлэгээний журмыг шинэчлэх;
  - Халдвартай үйлчлүүлэгчид түрээсэлсэн эсвэл хэрэглэсэн тээврийн хэрэгсэлд чиглэсэн тусгай журмыг хэрэгжүүлэх. Эдгээр тээврийн хэрэгслийг Засгийн газраас үндэсний хэмжээнд тогтоосон хугацаанд ашиглалгүй бүрэн ариутгах;
  - Хөдөлгөөний ачаалал ихтэй хэсэгт зөвшөөрөгдсөн спиртэн суурьтай гар ариутгагчийг бэлэн байлгах.

• Зочдод мэдээлэл авах болон хүн хоорондын зайг баримтлах арга хэмжээг хэрэгжүүлсэн байх:

  - Үндэсний хууль тогтоомжийн хүрээнд болон Мэдээлэл хамгаалах ерөнхий журам (GDPR)-ын дагуу оролцогчдыг ирэхээс өмнө эрсдлийн үнэлгээний асуулгыг аль болох цахимаар бөглүүлэх;



- Дотоодын хууль тогтоомжид заасны дагуу зочдын эрүүл мэнд/ температурын хяналтыг хэрэгжүүлдэг байх;
- Нэг машинд нэг дор байх хүний тоо болон байгууламжид нэг дор байх хүний тоог бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Автомашин түрээсийн байранд маск хэрэглэхийг зөвлөх;
- Жолооны үнэмлэхийг баталгаажуулахдаа сканнердахгүйгээр визуал таних уян хатан аргыг судалж үзсэн байх;
- Автомашиныг авах, эргүүлж өгөх үед ажилтны зайнаас харилцах харилцааг дэмжих, дараалал үүсгэхгүй байхад анхаарч, төлбөр хийх, автомашиныг буцааж авахдаа бүрэн дижитал процесс руу шилжих, мөн замын хажуугаас машиныг буцааж авах боломжийг судлах;

## 3.ОРОЛЦОГЧДЫН ИТГЭЛИЙГ СЭРГЭЭХ

**Ил тод байдал, зочидтойгоо харилцах замаар итгэл, итгэлцлийг сэргээхийн тулд автомашин түрээсийн үйлчилгээ эрхлэгч дараах зүйлс дээр анхаарна. Үүнд:**

- Байгууллагын дижитал болон шууд сувгуудыг ашиглан эрүүл мэнд, эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод, тогтмол хүргэх. Зочидтой тогтмол харьцах угтах үйлчилгээний ажилтнуудыг эрүүл мэндийн холбоотой асуултад хариулах чадвартай болгон сургаж бэлтгэх;
- Цахим захиалгын үйлчилгээг дэмжих;
- Захиалга хийх, цуцлахтай холбоотой дүрэм, журмын өөрчлөлт, хаагдсан салбарын талаар үйлчлүүлэгчдэд тодорхой мэдээлдэг байх;
- Хүн хоорондын зай, дарааллын менежментийг хэрэгжүүлэх зорилгоор шалан дээрх наалт, тэмдэг тэмдэглэгээ зэргийг ил тод, ойлгомжтой байдлаар байршуулж,

үйлчлүүлэгчдэд сайжруулсан цэвэрлэгээний удирдамж, хүн хоорондын зай барих шаардлагын талаар зөвлөмж өгдөг байх;

- Үйлчлүүлэгчдэд цэвэрлэгээ хийснээс хойш гар хүрээгүй, ашиглаагүй гэдэгт итгэл төрүүлэх зорилгоор цэвэрлэж ариутгасан тээврийн хэрэгсэлд тусгай таних тэмдэг бүхий битүүмжлэл бий болгох;
- Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу автомашин түрээсийн байгууламжид амны хаалт зүүх, гарын ариун цэврийг сахих, хүн хоорондын зай барих зэрэг мэдээллийг агуулсан зочдод зориулсан гарын авлага бэлтгэж, дүрэм журмыг тогтмол мэдээлэх.
- Онооны эсвэл гишүүнчлэл зэрэг урамшууллын хөтөлбөрийг жилээр сунгаж, захиалга цуцлах, түрээсийн хугацааг өөрчлөх, хил дамнасан түрээс, авах болон буцах байршилд өөрчлөлт оруулах зэргийг багтаасан үйлчилгээний нөхцлийг шинэчлэн боловсруулж, мэдээлэх.

# 4.УРАМШУУЛЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Автомашины түрээсийн үйлчилгээг сэргээхэд Засгийн газрын зүгээс бодлогын дэмжлэг үзүүлэх шаардлагатай. үйлчилгээний салбар байгууллагууд дараах хүсэлтийг Засгийн газарт тавьж байна:**

- Хил дамнасан аяллын шинэ дүрмийг боловсруулахдаа салбарын байгууллагууд болон бусад орны Засгийн газруудтай хамтран ажиллах;
- Татвар, төлбөр, хураамжийг бууруулах замаар салбарт санхүүгийн туслалцаа үзүүлэн эрэлтийг өдөөх; Орлого буурсан тохиолдолд нисэх онгоцны буудлууд автомашины түрээсийн компаниудыг жилийн баталгаат төлбөрөөс чөлөөлөх асуудлыг авч үзэх;
- Богино хугацааны түрээс, татварын урамшууллыг уртасгах, шууд дэмжлэг үзүүлэх;
- Аялал жуулчлалын дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор автомашин түрээсэлж аялах нь аюулгүй аяллын



# COVID-19 ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨГӨӨ, ЗӨВЛӨМЖ




ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЬЕ!
TAXI
Таксины жолооч Та:
ӨӨРИЙГӨӨ ХЭРХЭН ХАЛДВАРААС ХАМГААЛАХ ВЭ?
Гараа тогтмол угаах
Нэг удаагийн амны хаалт тогтмол зүүх
Амны хаалтыг 2 цаг тутамд солих
Нэг удаагийн бээлий өмсөх
Нүүр, ам, хамартаа хүрэхгүй байх
Гар халдваргүйжүүлэгч, нойтон салфетка, саван зэрэг хувийн хэрэгсэлтэй байх
Ковид-19 халдварын талаар мэдээлэлтэй байх, сэтгэлзүйгээ тайван байлгах
Автомашиндаа цэвэрлэгээ хийх үедээ хамгаалалтын хувцас хэрэглэлтэй байх
Ашигласан амны хаалт, бусад хог хаягдлыг аюулгүй байдлаар зайлуулж хаяж хэвших
Гэртээ гаднаас орохдоо халдвар хамгааллын дэглэмийг сайтар баримтлах
Халуун тэжээллэг хоол хүнс хэрэглэж, дархлаагаа дэмжих


"НИЙТИЙН ТАКСИ" ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ
КОРОНАВИРУСТ КОВИД-19 ХАЛДВАРААС СЭРГИЙЛЬЕ!
ЦУВРАЛ №07
"Нийтийн такси" үйлчилгээний аж ахуйн нэгжид:
АЖИЛЧДЫН БИЕИЙН ХАЛУУНЫГ ӨГЛӨӨ, ОРОЙД ҮЗЭХ
ТАКСИНД СПИРТЭН СУУРЬТАЙ ГАР АРИУТГАГЧ БАЙРШУУЛАХ
ТАКСИНД СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ,СЭТГҮҮЛ ТАВИХГҮЙ БАЙХ
ӨГЛӨӨ ЭЭЛЖИНД ГАРАХЫН ӨМНӨ ТАКСИНЫ ДОТОР, ГАДНА ЦЭВЭРЛЭГЭЭНД ХЯНАЛТ ТАВИХ
Жолооч нарт:
АМНЫ ХААЛТ ЗҮҮХ
БЭЭЛИЙ ӨМСӨХ
СПИРТЭН СУУРЬТАЙ ГАР АРИУТГАГЧ АВЧ ЯВАХ
ХҮНИЙ СУУДЛЫН ТОО ХЭТРҮҮЛЭХГҮЙ БАЙХ
КАБИНД ТАМХИ ТАТАХГҮЙ БАЙХ
ЦОНХ ОНГОЙЛГОЖ АГААР СЭЛГЭЛТ ХИЙХ (ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БУУХ БҮРТ НЭВТ САЛХИЛУУЛАХ)
КАБИН, ХААЛГАНЫ БАРИУЛ, ЖОЛООНЫ ХҮРД, МАШИНЫ ТҮЛХҮҮР, СУУДЛЫН БҮС ЗЭРГИЙГ ҮЙЛЧИЛГЭЭ ХООРОНД АРЧИЖ ЦЭВЭРЛЭХ
ХОГ ХАЯГДЛЫГ УУТАНД ХИЙЖ АМЫГ БООЖ ХАЯХ
СУУДЛЫН БҮРЭЭС, ШАЛАВЧИЙГ УГААЖ ЦЭВЭРЛЭХ
Үйлчлүүлэгчдэд:
АМНЫ ХААЛТ ЗҮҮХ
БЭЭЛИЙ ӨМСӨХ
АЛЬ БОЛОХ АРЫН СУУДАЛД СУУХ
БЭЛЭН МӨНГӨ АЛЬ БОЛОХ ХЭРЭГЛЭХГҮЙ
ТАМХИ ТАТАХГҮЙ





# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗМЭР, ҮЙЛЧИЛГЭЭ

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ



# ТАНИЛЦУУЛГА

Доорх удирдамжийг дэлхийн өнцөг булан бүрт байгаа аялал жуулчлалын үзмэрийн газруудыг аюулгүй, эрүүл, хариуцлагатайгаар дахин эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Аялал жуулчлалын үзмэрийн байгууллагын олон улсын холбоо" (IAAPA)-аас боловсруулж, санал болгож буй ойлголт, хүрээний дагуу эмхэтгэв. Уг удирдамжийн зорилго нь жуулчдын хэрэгцээ, хүлээлттэй уялдуулан эрүүл мэнд, аюулгүй байдал, хүн хоорондын зай барих шаардлагад илүү анхаарал хандуулсан холбогдох бүх чиг үүргийн нэгдсэн стандартыг бий болгоход оршино.

Эдгээр удирдамжид аялал жуулчлалын үзмэрийн газар гэж аквариум, соёл амралтын хүрээлэн, гэр бүлийн соёл амралтын төв, музей, шинжлэх ухааны төв, сэдэвчилсэн цэцэрлэгт хүрээлэн, усан парк, амьтны хүрээлэн болон бусад үзвэр, соёлын байгууламж, газруудыг хамруулж үзнэ. Мөн тогтмол бус байршилтай үйлчилгээ, нэг өдрийн аялал, автобустай аялал жуулчлалын үйлчилгээ багтсан болно. Дурдсан газрууд нь спортын хүрээлэн, концерт тоглолт гэх мэт олон нийтийн томоохон цуглартаас ялгаатай нь хүмүүсийн багтаамжийг хянах эсвэл багасгах замаар хүн хоорондын зайн дүрмийг баримтлах боломжтой юм. Түүнээс гадна эдгээр үзмэрт үйлчлүүлэгчийн зарцуулах хугацаа хязгаарлагдмал бөгөөд зочдын ихэнх хувь нь нэг бүлийн гишүүд байдаг тул хүн хоорондын зай барих шаардлагагүй байдаг.

Цаашид вирусын тухай мэдээлэл нэмэгдэхийн хэрээр удирдамж нь шинэчлэгдэн, сайжрахыг анхаарна уу. Энэхүү удирдамжийг аялал жуулчлалын үзмэрийн байгууллагууд өөрсдийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн бүх аялал жуулчлалын үзмэрийн байгууллага дотоодод мөрдөгдөж буй хууль, тогтоомж, ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг дагаж мөрдөх хэрэгтэй.

Тодорхойлсон арга хэмжээ нь халдвар тархах өндөр эрсдэлтэй нөхцөл байдалд тулгуурласан болохыг тэмдэглэх нь чухал юм. Тиймээс хэрэгжүүлэхдээ тодорхой цаг хугацаанд хязгаарлах бөгөөд нийгмийн эрүүл мэндийн мэдээлэлд үндэслэн дахин үнэлж, тогтмол хяналт тавьж байх ёстой. Эрсдэл буурах тусам дагаж арга хэмжээг сулруулж, цаашид илүү үр дүнтэй, тохиромжтой, хэрэгжүүлэхэд хүндрэл багатай, шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээ авах боломжтой байх нь чухал.

Аялал жуулчлалын салбар Ковид19-ийн хямралаас сэргэхэд аялагчид өөрсдийгөө аюулгүй гэдэгтээ итгэлтэй байх нь чухал юм. Иймээс тэдний аюулгүй байдлыг хангах ямар арга хэмжээ, журам хэрэгжүүлж байгаагаа энгийн, ил тод байдлаар тэдэнд мэдээлэх хэрэгтэй.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бүх хүнд илүү хялбар болгох үүднээс удирдамжийг дараах 4 үндсэн хэсэгт хуваасан болно. Үүнд:

1. **Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Аялагчдын итгэлийг сэргээх**
4. **Урамшууллын бодлого хэрэгжүүлэх**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЖИЛТНУУДЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

**Аялал жуулчлалын үзмэрийн байгууллагууд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхдээ үйл ажиллагааны чанар, нийлүүлэлтийг сайжруулж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажилтнуудыг бэлтгэсэн байх шаардлагатай.**

- Дараах нөхцлүүдийг хангаснаар аялал жуулчлалын үзмэрийн байгууллагуудын үйл ажиллагааг дахин эхлүүлэх боломжтой:
    - Засгийн газраас үйл ажиллагаагаа явуулах, сэргээхэд шаардлагатай бүх зөвшөөрөл, лиценз авсан байх;
    - Ковид19 цар тахлын халдвараас урдчилан сэргийлэх арга хэмжээ /хяналтын хуудас, тусгай ариутгал, цэвэрлэгээ г.м зүйлсийг багтаасан/-ний цогц төлөвлөгөө боловсруулах;
    - Ажилтнуудын эрүүл мэндэд зориулсан дотоод журам, зааварчилгаатай байх, үндэсний хууль тогтоомжийн шаардлагын хүрээнд эрүүл мэндийн үзлэгт хамруулах. Хэрэв ийм шаардлага байхгүй бол ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу Ковид19-ийн шинж тэмдэг үзүүлж буй эсвэл өндөр халуунтай ажилтныг гэрээр ажиллуулах, амраах журамтай байх;
    - Дотоодын хууль тогтоомжид хүн хоорондын зай барих шаардлагын тухай заасан бол оффисын зохион байгуулалт дахь орон зайг тооцоолж, ажиллагсдын тоог хязгаарлах. Боломжтой тохиолдолд ажлын байран дахь эрсдлийг бууруулах зорилгоор нягтралыг багасган, ажилтнууд тогтмол ээлжинд гэрээсээ ажиллах нөхцлийг дэмжих;
    - Ажилтнуудад зориулсан хувцас угаалгын үйлчилгээ, хоол хүргэлтийн сонголтыг тооцоолох;
    - Бэлэн байдлыг хангах үүднээс давхрын зохион байгуулалтын план зургийг ил байрлуулах;
    - Хавьтлыг аль болох багасгах зорилгоор зайнаас харилцах дүрэм боловсруулах. Дотоодын хууль тогтоомжид заасан бол эрсдэлд суурилсан хандлагыг ашиглан хүн хоорондын зай барих шаардлагыг хэрэгжүүлэх, үйлчлүүлэгчийн дараалал үүсч болзошгүй хэсэг, бусад боломжтой газруудад тэмдэглэж, харуулах. Боломжтой тохиолдолд үйлчлүүлэгчийн дараалал зохицуулах цахим систем ашиглах;
    - Эрсдлийн үнэлгээнд үндэслэн өөрийн ажилтнуудыг хамгаалалтын халхавч болон амны хаалт, бээлий гэх мэт хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ)-ээр хангах;
    - Боломжтой бол зайнаас харьцах цэгүүд, цахим төлбөр гэх мэт автоматжуулалтын төхөөрөмж нэвтрүүлэх. Хэрэв зайнаас төлбөр хийх боломжгүй бол бээлий, гар ариутгагч ашиглах;
    - Мэргэжлийн байгууллага, төрийн байгууллага, ДЭМБ-ын зааварчилгаанд нийцсэн ариутгал цэвэрлэгээний төхөөрөмж (ариутгалын шүршигч төхөөрөмж г.м), инноваци судлаж, томоохон аялал жуулчлалын үзмэр газарт байрлуулах, шилдэг туршлагаа хуваалцах;
    - Ресторан, кафе, киоск, зочид буудал болоод нийтийн тээврийн салбарын түншүүддээ үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах үүднээс дотоодын хууль тогтоомжид суурилсан хууль дүрмийг мөрдөж буйг ойлгуулж, тэд мөн ижил төстэй удирдамж мөрдөж буй эсэхэд анхаарах. Энэ талаар “Зочлох үйлчилгээ” болон “Тур оператор”-т зориулан бэлтгэсэн удирдамжуудаас дэлгэрэнгүй мэдэх боломжтой;

  - Халдварын тохиолдол илрэх үед хэрэгжүүлэх Ковид19-ийн онцгой байдлын төлөвлөгөөг нийлүүлэгчид болон түншүүдтэй хамтран боловсруулсан байх;
  - Бүхий л тохиолдолд үйл ажиллагааг илүү аюулгүй явуулах боломжууд судалсан байх (Тасалбарын системийг сайжруулах, үйлчлүүлэгчийн тоог хязгаарлах болоод орох цаг хугацааг зөрүүлэх байдлаар).

- Аялал жуулчлалын үзмэрийн байгууллагууд ажилтнуудаа дараах байдлаар бэлтгэн сургасан байна:

  - Ажилтнуудад зориулсан дотоод журам, үйл ажиллагааны зааварчилгаа болон ТАА / Түгээмэл асуугддаг асуултууд/ боловсруулж, хэрэгжүүлэх;
  - Халдварыг хянах, хүн хоорондын зай барих шаардлага, гараа тогтмол угаах, маск, бээлий хэрэглэх тухай үндэсний хэмжээнд мөрдөж буй дүрэм, журам, түүнчлэн илүү нарийвчилсан арга хэмжээ авах талаар дотоод журам байгаа бол эдгээр сэдвээр ажилтнуудаа давтан сургах;
  - Зочид буудал, тээврийн компани зэрэг хамтран ажилладаг байгууллагуудад ижил төстэй сэдвээр ажилтнуудаа сургах талаар хүсэлт тавих;
  - Бүх сургалтад ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх;
  - Ажилтны өвчний чөлөө олгох журмыг хянаж, шаардлагатай бол шинэчлэх;
  - Ажилтнуудын эрүүл мэндэд байнгын анхаарал хяналт тавьж, тэднийг Засгийн газар болон ДЭМБ-ын заавар зөвлөмжийг даган мөрдөхөд нь урамшуулан, манлайлж ажиллах.

# 2.ХАРИУЦЛАГАТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

**Аялал жуулчлалын үзмэрүүд сайжруулсан ариун цэвэр, ариутгалын арга хэмжээгээр дамжуулан үйлчлүүлэгчдийн аюулгүй үйлчилгээ авах нөхцлийг хангахдаа дараах арга хэмжээ авсан байна. Үүнд:**

- Ханган нийлүүлэгч байгууллагуудын авч хэрэгжүүлж буй нэмэлт нарийвчилсан удирдамжтай танилцана.

- Эрчимжүүлсэн ариутгал, халдваргүйтгэл, гүн цэвэрлэгээний арга хэмжээг ойр давтамжтай хийхэд чиглэсэн дүрэм, журам боловсруулсан байна.

  - Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
  - Цэвэрлэгээний журамд өөрчлөлт оруулахдаа өөртөө үйлчлэх тоног төхөөрөмж, аюулгүй байдлын хяналтын цэг, угаалгын өрөө, цахилгаан шат, шатны бариул, нийтийн эзэмшлийн талбай зэрэг ялангуяа гар болон биеэр хамгийн их хүрэлцэх хэсгүүдийг цэвэрлэхэд онцгой анхаарал хандуулж, цэвэрлэгээний ажилтнуудад тогтмол сургалт явуулах. Шаардлагатай тохиолдолд тэрэг, цахилгаан шат, тэргэнцэр зэргийг хэрэглээ болгоны дараа цэвэрлэх. Цэвэрлэгээ ариутгалын давтамжийг зохих хэмжээгээр ихэсгэх. Онцын шаардлагагүй эд зүйлсийг зайчлах.
  - Цахилгаан шатаар зорчих удирдамжийг зочдод мэдээлэх;
  - Хөдөлгөөн ихтэй хэсэгт зөвшөөрөгдсөн спиртэн суурьтай гар ариутгагчийг зочдод зориулан бэлэн байлгах. Аялагч, жуулчдад зориулж ариутгалын нэмэлт бүтээгдэхүүнийг өгөх эсвэл худалдан авах боломжтой болгох;

- Тээврийн түнш болон ханган нийлүүлэгч байгууллагууд ариутгал, гүн цэвэрлэгээний холбогдох дүрэм журмыг мөрдөж буйг бататгах;
- Хог хаягдлын ачилтын давтамжийг ихэсгэх, менежментийг сайжруулах;
- Алчуур бусад холбогдох хэрэгслийг өндөр хэмтэй ус, угаалгын бодис ашиглан хатааж хэрэглэх;
- Дотоодын хууль тогтоомжийн дагуу хоорондын зай барих шаардлагыг хангах үүднээс нэг зэрэг үйлчлүүлэх хүмүүсийн тоон хязгаарыг аялал жуулчлалын үзмэрийн хэсэг тус бүрийн онцлогт тааруулан бууруулах;
- Шаардлагатай болон дотоодын хууль тогтоомжид заасан тохиолдолд үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн нотолгоо гаргуулах;
- Үйлчлүүлэгчдийн бөөгнөрөл үүсч, хоорондын зай барих нөхцөл бүрэлдэхгүй байгаа тохиолдолд дотоодын хууль тогтоомжид нийцсэн байдлаар зохицуулах;
- Үйлчлүүлэгчдийг маскаар хангаж, зүүх хэрэгтэйг сануулах;
- Цахимаар тасалбар худалдаж авах сонголтыг сурталчилж, олон нийтэд хүртээмжтэй санал урамшуулал бий болгох;
- Үйлчлүүлэгчдийн нэвтрэх, гарах хугацаанд тохируулга хийж, бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх (нэмэлт үзүүлбэр, үзүүлбэрийн дараах богино арга хэмжээ зохион байгуулах г.м):
- Халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчдийг тусгаарлах хэсэг бэлдэх;
- Үйлчлүүлэгчийн биедээ авч явах хувийн эд зүйлийг багасгах. Хувийн эд зүйлс хадгалах тээш, шүүгээний менежментийг сайжруулах.

• Онцгой газруудад тусгай чиг үүрэг, журам дагаж мөрдөх. Жишээлбэл:

  - Галзуу хулгана, унадаг дугуй унах зэрэг аливаа унаагаар үйлчлүүлж буй тохиолдолд маск зүүхийг зөвлөх. Ингэхдээ маск нь хэт сул байх, бусдад саад учруулах эрсдэл дагуулахгүй байхад анхаарах. Хэрэв байгууламжийн ажилтан өөрийн биеэр аюулгүй байдлыг шалгах тохиолдолд (хаалга түгжээтэй байгаа эсэхийг шалгах болон бусад аюулгүй байдлын арга хэмжээ) гараа сайтар ариутгах;
  - Усан паркийн хувьд интерактив, тоглоомын шинж чанартай хэсгийг хаах эсвэл холдуулах.

• Түнш ресторан, кафе нь зочдыг хамгаалах дараах эрүүл мэнд, ариун цэвэр, ариутгал, эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын удирдамжийг дагаж мөрдөх шаардлагатай. Үүнд:

  - Зөвшөөрөгдсөн спиртийн агууламж бүхий гар ариутгагчийг шаардлагатай хэмжээгээр нэвтрэх цэгт байршуулах;
  - Ресторан болон ажилтнууд холбогдох эрүүл ахуй, ариун цэвэр, ариутгалын дүрмийг мөрдөж буй эсэхийг бататгах;
  - Буфетийн хэсэгт зочдыг өөрсдөөр нь хүнсэнд хүргүүлэхгүй байх;
  - Үйлчлүүлэгдийн хэрэглэсэн тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэх;
  - Ус, ундаанд зориулсан удирдамж боловсруулах. Үйлчлүүлэгчид өөрсдийн усны савыг биедээ авч явах;
  - Зочдыг гармагц ширээг ариутгах, нэн даруй цэвэрлэх;
  - Ширээ, зочдын суудал хоорондын зайн шаардлагыг баримтлах;
  - Зочдын ширээн дээр тавих эд зүйлсийн тоог багасгаж, боломжтой бол багцалж, ариутгасан хэрэгсэл ашиглах;

- Нийлүүлэгч байгууллагаас урьдчилан бэлтгэсэн хоол хэрэглэх бол холбоотой удирдамж боловсруулах;
- Зайнаас төлбөр төлөх боломжуудыг чухалчлах;
- Ажиллах цагийг уртасгах замаар нэг зэрэг үйлчлүүлэх хүмүүсийн тоог багасгаж, бусад шаардлагатай арга хэмжээ хэрэгжих боломжийг бүрэлдүүлэх.

# 3.АЯЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ СЭРГЭЭХ

**Үйлчилгээний ил тод байдал, найрсаг харилцаанд тулгуурлан аялагчдын итгэлийг сэргээхийн тулд дараах зүйлс дээр анхаарна. Үүнд:**

- Байгууллагын дижитал болон шууд сувгийг ашиглан эрүүл мэнд, эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод байдлаар тогтмол хүргэх. Шинэчилсэн цэвэрлэгээ ариутгалын дүрэм, зайнаас харилцах болон бусад зөвлөмжүүдийн талаар ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээ үйлчлүүлэгч нарт харагдахаар байрлуулах;
- Бөөгнөрөл багасгах технологийн хэрэглээг нэвтрүүлж, чухалчлах;
- Гарын ариун цэвэр, маск, хамгаалалтын хэрэгсэл зүүх, зайнаас харьцах зэргийг агуулсан чиг үүрэг, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудын шийдвэрт тулгуурлан үйлчлүүлэгчид урьдчилсан байдлаар, шаардлагатай тохиолдолд нэвтрэх цэгт ойлгуулах;
- Үйлчлүүлэгчдэд асуудал тулгарсан тохиолдолд аялал жуулчлалын үзмэрийн байгууллагаас дэмжлэг авах боломжтойг тайлбарлах. Зочидтой тогтмол харьцах угтах үйлчилгээний ажилтнуудыг эрүүл мэндийн холбоотой асуултад хариулах чадвартай болгох, үйлчлүүлэгч нар дүрэм мөрдөхгүй байх, халдварын шинэ тохиолдлын байршил тогтоох зэрэг бэрхшээлийг шийдвэрлэх чадварт сургаж бэлтгэх. Байгууллагын үүрэг хариуцлагаас гадна үйлчлүүлэгч нар өөрсдийн хариуцлагыг ойлгож ухамсарлахад анхаарах;
- Байгууламжийн хэмжээг харгалзан үзэж тохирох эмнэлгийн тусламж үйлчилгээний цэг байгуулж, байгууллагын ажилтнууд Ковид19 халдварын тохиолдолтой зөв харьцах чадварт суралцсан байх;
- Дотоод дүрэм журамд заасны дагуу хавьтал мөшгөх апликейшны хэрэглээг дэмжих.

# 4.УРАМШУУЛЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Аялал жуулчлалын үзмэрийн байгууллагууд эргэж сэргэхэд Засгийн газрын дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Иймээс салбарынхан Засгийн газарт дараах хүсэлт тавих хэрэгтэй:**

- **Дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зорин очих газрын сурталчилгааг сайжруулах;**
- **Богино хугацааны түрээс, татварын урамшууллыг уртасгах, шууд дэмжлэг үзүүлэх;**
- **Татвар, төлбөр, хураамжийг бууруулах замаар салбарт санхүүгийн туслалцаа үзүүлэн эрэлтийг өдөөх;**




# АДАЛ ЯВДАЛТ
# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

WORLD TRAVEL & TOURISM COUNCIL

#АЮУЛГҮЙ_АЯЛАЛ



# ТАНИЛЦУУЛГА

Адал явдалт аялал жуулчлалын салбарт зориулсан дараах удирдамжийг Адал явдалт аялал жуулчлалын худалдааны холбоо (АТТА)-оос гаргасан баримт бичигт үндэслэн боловсруулсан юм. Энэхүү баримт бичгийн зорилго нь хүн хоорондын зай барих шаардлага, эрүүл мэнд, эрүүл ахуйн асуудалд илүү төвлөрсөн, аялагчдын хүсэн, хүлээж буй аюулгүй байдлыг эрхэмлэсэн холбогдох бүх чиг үүргийн стандартыг бий болгоход оршино.

Энэхүү удирдамжид адал явдалт аялал жуулчлал гэдэгт дугуйн аялал, рафтин, явган аялал, цана, сноуборд, зэрлэг ан амьтдыг үзэх аялал,  хоолны аялал гэх мэт бусад олон төрлийн адал явдалт аялал жуулчлалыг хамруулан авч үзнэ. Эдгээр арга хэмжээ ихэвчлэн гадаа явагддаг ба дотор орон зайд өнгөрөөх хугацаа бага, хүни тоо хязгаарлагдмал байдаг. Гэхдээ хүн хоорондын зайг баримтлахын тулд хүний тоог багасгаж болно.

Цаашид вирусын тухай мэдээлэл нэмэгдэхийн хэрээр удирдамж нь шинэчлэгдэн, сайжрахыг анхаарна уу.  Эдгээр удирдамж нь адал явдалт аялал жуулчлалын салбарын бүх бизнес эрхлэгчдэд хамаарахгүй ба уг мэдээлэл нь зааварчилгаа өгөх зорилготой юм. Бүх адал явдалт аялал жуулчлалын үйл ажиллагаанд орон нутгийн, үндэсний хууль тогтоомж болон ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн зөвлөмж, зааварчилгааг дагаж мөрдөхийг зөвлөж байна.

Тусгайлан заасан арга хэмжээ нь вирус тархах өндөр магадлалтай нөхцөлд зориулж боловсруулагдсан учир эрсдэл багасахын хэрээр тохируулан ашиглах нь зүйтэй. Мөн авсан арга хэмжээ, тогтоосон журмыг тогтмол хугацаанд дахин нягталж үзэх шаардлагатай. Эрсдэл буурах тусам дагаж арга хэмжээг сулруулах буюу илүү үр дүнтэй, тохиромжтой, хэрэгжүүлэхэд хүндрэл багатай, шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээг хэрэгжүүлэх боломж олдмогц өмнө авч байсан үр дүн багатай арга хэмжээг хүчингүй болгох хэрэгтэй.

Аялал жуулчлалын салбар Ковид19-ийн хямралаас гарахад аялагчид өөрсдийгөө аюулгүй гэдэгтээ итгэлтэй байх явдал юм. Иймээс тэдний аюулгүй байдлыг хангах үүднээс ямар арга хэмжээ, журам хэрэгжүүлж байгаагаа энгийн, ил тод байдлаар тэдэнд мэдээлэх  хэрэгтэй.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бүх хүнд илүү хялбар болгох үүднээс зөвлөмжийг дараах 4 бүлэгт хуваасан. Үүнд:

1. **Үйл ажиллагааны болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах**
2. **Хариуцлагатай, аюулгүй үйлчилгээ үзүүлэх**
3. **Аялагчдын итгэлийг сэргээх**
4. **Урамшууллын бодлого хэрэгжүүлэх**

# 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЖИЛТНУУДЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

Адал явдалт аялал жуулчлалын компаниуд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхдээ үйл ажиллагааны чанар, хүргэлтийг оновчтой болгож, үйл ажиллагааны төлөвлөгөө бэлтгэж, гүйцэтгэх бэлтгэгдсэн ажилтантай байх ёстой.

**Дараах нөхцлийг бүрдүүлсэн адал явдалт аялал жуулчлалын компаниудын үйл ажиллагаагаа дахин эхлүүлэх боломжтой. Үүнд:**

- Засгийн газраас үйл ажиллагаагаа явуулах, дахин сэргээхэд шаардагдах бүх зөвшөөрөл, лиценз авсан байх;
- Ариутгал, цэвэрлэгээний тусгай төлөвлөгөө, онцгой байдлын төлөвлөгөө, хүлээн авагч орнуудын эрсдлийн нөхцөл байдал, орон нутгийн компаниуд, орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийг хянах үйл явц, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ/хяналтын хуудас зэргийг багтаасан Ковид19 төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг байх;
- Хэрэв үндэсний хууль тогтоомжид ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн удирдамж болон протокол гаргах шаардлагатай гэж үзсэн бол зааврын дагуу хийж хэрэгжүүлсэн байх. Нийгмийн эрүүл мэндийн байгууллага болон/эсвэл ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу шинж тэмдэгтэй, өндөр халуунтай ажилтныг гэртээ байх журам боловсруулж, мэдээлэх;
- Хэрвээ үндэсний хууль тогтоомжид тусгасан бол нэг дор ажиллах ажилтны тоог хязгаарлах. Эрсдлийг бууруулах зорилгоор ажилтныг ээлжээр ажиллуулах, боломжтой тохиолдолд ажлын байрны нягтарлыг багасгах зорилгоор гэрээс ажиллах зарчмыг дэмждэг байх;
- Ажилтнуудын өвчний чөлөөний дүрэм журмыг дахин хянаж, шаардлагатай гэж үзвэл шинэчилсэн байх;
- Зайнаас харилцах харьцааг дэмсэн журам гаргаж хэрэгжүүлсэн байх. Эрсдлийн үнэлгээнд үндэслэн ялангуяа дараалалд мөрдөх хүн хоорондын зайн удирдамж гаргаж хэрэгжүүлсэн байх; Үндэсний хууль тогтоомжид заасны дагуу зочин болон ажилтанд хоорондын зай барих, маск зүүх зэрэг зааврыг мэдээлэх зорилгоор ил харагдахуйц тэмдэг тэмдэглэгээ байрлуулах;
- Адал явдалт арга хэмжээний эрсдэл нь харилцан адилгүй байдаг тул хүн хоорондын зай барих, амны хаалт зүүх зэрэг шаардлагыг тодорхойлохын тулд үйл ажиллагаа бүрийн эрсдлийн үнэлгээг хийсэн байх;
- Замын хөдөлгөөны ачаалал их бүсээс зайлсхийхийн тулд боломжит газруудад өөр хувилбар бүхий зам, үйл ажиллагаа явуулах бүс нутаг төлөвлөсөн байх мөн газарзүйн байдал, хүндрэлийн түвшин, зам, цас, гол, далай, усны нөхцөл зэрэг хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг харгалзан үзэж хүн хоорондын зай барих шаардлагыг зөвлөх;

- Газарзүйн байдал, хүндрэлийн түвшин, зам, цас, гол, далай, усны нөхцөл зэрэг хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр боломжтой бол замын хөдөлгөөний ачаалал ихтэй хэсгүүдээс зайлсхийх, хүн хоорондын зай барих зорилгоор өөр чиглэл, үйл ажиллагааны зураглалыг гаргасан байх;
- үндэсний хууль тогтоомжийн шаардлагын дагуу хийсэн эрсдлийн үнэлгээнд үндэслэн бүх ажилтанд хувийн хамгаалах хэрэгсэл болох маск, гар ариутгагч гэх мэт зүйлсийг бэлтгэсэн байх. Хүйтэний улиралд ариутгагч бодисыг 0 оС/32 oF дээш хэмд байлгах;
- Боломжтой бол зайнаас төлбөр хийх төхөөрөмж гэх мэт автоматжуулсан технологи нэвтрүүлэх; хэрэв боломжгүй бол бээлий, гар ариутгагч ашиглах;
- Мэргэжлийн хүмүүс, Засгийн газрын болон ДЭМБ зэрэг байгууллагаар баталгаажсан цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлийн шилдэг туршлагыг тодорхойлж, сургасан байх;
- Үндэсний хууль тогтоомжийн шаардлагын дагуу ресторан, ТҮЦ, зочид буудал, тоног төхөөрөмж нийлүүлэгч, тээврийн түнш зэрэг хамтран ажилладаг, түнш байгууллага нийлүүлэгч зочдын эрүүл мэнд, эрүүл ахуйг хамгаалах талаар ижил төстэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд анхаарах; Зочлох үйлчилгээ, тур операторт зориулсан дэлгэрэнгүй зөвлөмжийг ДАЖЗ-ийг протоколоос үзнэ үү.
- Ажилтан болон зочдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах;
- Аяллын үеэр болон дараа халдварын болзошгүй тохиолдолд нийлүүлэгч болон түншүүдтэй хамтран авч хэрэгжүүлэх Ковид19 яаралтай нөхцөл байдлын төлөвлөгөөг орон нутаг, үндэсний хууль тогтоомжийн хүрээнд боловсруулж, танилцуулсан байх;
- Боломжтой тохиолдол урьдчилан тасалбар авах, хуваарийн дагуу бүртгэх, хөөрөх, буух хугацааг зөрүүлэх, маршрутын эхлэх цэгийг өөр өөр хэсэгт сонгох, цана өргөх зайг тохируулах, жижиг бүлгүүд гэх мэт үйл ажиллагааны боломжит бусад хувилбаруудыг судлан гаргасан байх.

**Аядал явдалт аялал жуулчлалын компани нь үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэхэд ажилтнуудаа дараах байдлаар сургах нь зүйтэй.**

- Ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдамж, ТАА /түгээмэл асуугддаг асуултууд/ боловсруулж, хэрэгжүүлэх;
- Үндэсний эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу зайнаас харьцах, халдвар хамгааллын дэглэмийг сахихтай холбоотой шаардлагатай мэдээлэл болон тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл, маск, бээлийгээр хангах:
- Адал явдалт аялал нь нэгээс дээш орныг хамарч байвал тухайн орнуудын аяллын хориг болон аяллын үйл ажиллагааны дарааллыг ажилтанд ойлгуулах;
- Аялал жуулчлалын салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зочид буудал, тээвэр, үйл ажиллагааны гол түнш байгууллагууд ижил төстэй дүрэм, журам боловсруулж, ажилтнуудаа сургасан байхад анхаарах;
- Бүх сургалтанд нийгмийн эрүүл мэндийн байгууллага эсвэл ДЭМБ-ын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх;
- Ажилтнуудын эрүүл мэндэд байнгын анхаарал хяналт тавьж, тэднийг Засгийн газар болон ДЭМБ-ын заавар зөвлөмжийг даган мөрдөхөд нь урамшуулан, манлайлж ажиллах;
- Тусгаарлах, тээвэрлэх, нүүлгэн шилжүүлэх зэрэг онцгой байдалд ажилтанг бэлтгэх.



## 2.ХАРИУЦЛАГАТАЙ, АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

**Адал явдалт аялал жуулчлалын компаниуд нь цэвэр цэмцэгэр байдал, эрүүл ахуйн шилдэг туршлагаар дамжуулан ажилтнууд болон зочдын аюулгүй байдлыг ханган ажиллахын тулд дараах зүйлийг дагаж мөрдөх шаардлагатай. Үүнд:**

- Нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэх талаар ханган нийлүүлэгч, түнш байгуулагуудтай хамтран ажиллах;
- Ариутгал, цэвэрлэгээний арга хэмжээг сайжруулж, цэвэрлэх/ариутгах давтамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байх. Үүнд:
  - Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
  - Хүний гар байнга хүрдэг хэсэгт ялангуяа тоног төхөөрөмж, бариул, нийтийн эзэмшлийн талбай, угаалгын өрөөний цэвэрлэгээнд илүү төвлөрсөн цэвэрлэгээний багийн журамд өөрчлөлт оруулах. Шаардлагатай бол цэвэрлэх давтамжийг нэмэгдүүлж, цэвэрлэгээ хоорондын хугацааг тогтоох. Онцын шаардлагагүй эд хэрэгслийг зайчлах;
  - Үйл ажиллагаа болон аяллын үеэр зайнаас харьцах мөн эрүүл мэндийн бусад арга хэмжээний талаар оролцогчид мэдээлэл өгөх;
  - Зочдод зориулж томоохон их дэлгүүр, хоол хүнсний газар, цахилгаан шат зэрэг хөл хөдлөгөөн ихтэй газруудад стиртэн суурьтай эсвэл гипохлоридийн хүчил агуулсан гар ариутгагч байршуулж, зочдод ариутгалын бодис ашиглах боломжийг олгох. Боломжтой бол зочдод зориулж ариутгалын нэмэлт бүтээгдэхүүнийг өгөх эсвэл худалдан авах боломж олгох;



- Тээврийн түнш, ханган нийлүүлэгч ариутгал, халдваргүйтгэл, гүн цэвэрлэгээний үйл явцыг ижил төстэй байдлаар боловсруулсан байхад анхаарах;
- Хог хаягдлыг байршлаар нь эсвэл үйл ажиллагааны дагуу зайлуулах давтамжийг зохих ёсоор сайжруулах;
- Засгийн газар болон эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ зэрэг)-аас тогтоосон арга, угаалгын нунтаг, өндөр температурт угаагч, хатаагчийн тохиргоог ашиглан алчуур мөн тоног төхөөрөмжийг угааж, цэвэрлэдэг байх.

• Үндэсний хууль тогтоомжийн дагуу оролцогчид хүн хоорондын зай барих нөхцлийг бүрдүүлэх, тэдгээрийн тоонд хязгаарлалт тавьсан байх. Үйл ажиллагааны хэсэг тус бүрийн эрсдэлийн өөр өөр түвшинд үндэслэн хариу арга хэмжээг авах;

• Аврах үйл ажиллагааг хүндрүүлэхгүй байх үүднээс үйл ажиллагааны төвшинг аялагчийн ур чадвараас давуулахгүй байх;

• Хэрэглэгч мэдээлэл авах, тоног төхөөрөмжтэй харицах үеийн биеэр болон гараар хүрэлцэх нөхцлийг хамгийн бага түвшинд хүртэл бууруулах;

- Эрүүл мэнд болон аюулгүй байдлын хамтын хариуцлагыг сурталчилдаг байх;
- Үндэсний хууль тогтоомжид заасны дагуу зочдын эрүүл мэнд/ температурын хяналтыг хэрэгжүүлдэг байх;
- Зай барих, дараалал үүсгэхгүй байх;
- Нийтийн эзэмшлийн талбай, цахилгаан шат, байгалийн үзэсгэлэнт газар, дэлгүүр, гадаа хоолны газар гэх мэт олон хүн цугласан газруудад бусад группын хүмүүстэй зайнаас харьцах;
- Ачаалал ихтэй бүс нутгийн аяллын үйл ажиллагааны эхлэх болон дуусах цагийн хуваарь гарган компаниуд хооронд зохицуулалт хийх. Тухайлбал рафтинг завьны аяллын эхлэх болон дуусах цэгийг тодорхойлох;

- Эрүүл болон аюулгүй байдлын талаар аялал эхлэхээс өмнө зочдод мэдэгдэх;
- Зочдод өөрсдийн нүүрний хаалт болон тухайн үйл ажиллагаанд тохирсон өөрийгөө хамгаалах бусад хэрэгсэл авч ирэхийг зөвлөх. Жишээлбэл цана болон сноубордоор гулгах нь явган аялахаас өөр байдаг. Зочдын ирсэн газар болон бүх тээврийн хэрэгсэлд маск, нүүрний хаалт зүүхийг уриалах.
- Цахим үйл ажиллагааг сайжруулах, зайнаас харьцах технологийг дэмжих;
- Бүх шаардлагатай зүйлсийг багтаасан аяллын багц болон тасалбарыг цахимаар худалдан авах боломжийг сайжруулах. Ажлын байран дээр авч ирдэг өөрсдийн хувийн эд зүйлсийн тоо хэмжээг багасгахыг уриалах. Хэрвээ шаардлагатай бол хүн бүрд шүүгээ гаргаж өгөх;
- Тухайн бүлгээс гадуурх хүмүүсийн өртөх эрсдлийг бууруулахын тулд бүх үйл ажиллагаанд гэр бүл, группын гишүүдийг нэг дор хамтад нь байлгах;
- Хувцас солих өрөө, төхөөрөмж буцааж авах хэсэгт хүн хоорондын зай барих, харилцах боломжийг хамгийн бага байлгах үүднээс зай барих, цагийн хуваарь гаргах болон орох хүмүүсийн тоог тогтоох арга хэмжээ хэрэгжүүлэх;
- Аяллын үеэр зочдын өөрсдийнх нь тоног төхөөрөмжийг хаана ашиглах боломжтой болохыг мэдэгдэх. Зочдыг өөрсдийн төхөөрөмжүүдийг тухайлбал унадаг дугуй, цана, хамгаалах малгай гэх мэт бусад зүйлс авч ирэхийг уриалах;
- Завиар аялах үйл ажиллагааны зарим хэсэгт усанд унах эрсдэлтэй учраас нүүрний хаалт хэрэглэхийг зочдод зөвлөхгүй байх;
- Тодорхой үйл ажиллагаанд зориулж өвөрмөц удирдамж боловсруулах. ялангуяа: цугларах цэг, рафтинг, дугуйн болон алхалтын замууд, нүүрний хаалт зүүхийг шаардах, зай барих боломжтой бол тус тусад нь тээвэрлэх, мөн аяллын үргэлжлэх хугацаанд тээврийн хэрэгслийн агааржуулалтыг харгалзан үзэх;
- Зочдыг зэрлэг ан амьтадаас зай барихыг сануулах. Хэдийгээр хүнээс амьтанд вирус халдварласан тохиолдол маш цөөхөн боловч үүнийг нотлох шинжлэх ухааны баримт маш бага байдаг. Иймээс хүнээс амьтанд вирус халдварлах нь ховордож буй амьтдадыг мөхлийн аюулд хүргэж болзошгүй юм.



# 3.АЯЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ СЭРГЭЭХ

**Адал явдалт аяллын компаниуд ил тод байдал, зочидтойгоо харилцах замаар итгэл, итгэлцлийг сэргээхийн тулд дараах зүйлс дээр анхаарна. Үүнд:**

- Байгууллагын дижитал болон шууд сувгуудыг ашиглан эрүүл мэнд, эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод, тогтмол хүргэх;
- Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан нүүрний маск эсвэл халхавч зүүх, гарын ариун цэвэр сахих болон зайнаас харьцах зөвлөмжийг аялал эхлэхээс өмнө цахимаар өгөх, ирсэн аялагчдад биечилсэн байдлаар өгч байх. Үйлчлүүлэгчид зөвлөмжтэй танилцсан эсэхийг тодруулах;
- Аливаа асуулт эсвэл асуудал гарсан бол тусламж үзүүлэхэд бэлэн гэдгийг зочдод мэдэгдэх. Зочидтой харилцаж буй ажилтан асуултанд хариулах, халдварын шинэ тохиолдлыг илрүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зочид дүрэм, журам дагаж мөрдөхгүй байгаа нөхцөл байдлыг тайлагнах, аяллын өмнө эсвэл үйл ажиллагааны үеэр зөвлөмж, журам танилцуулах зэрэгт сургаж, бэлтгэгдсэн байх. Адал явдалт аяллын компани болон үйлчлүүлэгчид хаируцлага хамтран үүрдэг болохыг мэдэгдэх;
- Үндэсний хууль тогтоомжид зөвшөөрсөн бол хавьтлыг мөшгөх аппликейшн ашиглах.

# 4.БОДЛОГЫН ТҮВШИНД ДЭМЖЛЭГ АВАХ

**Адал явдалт аялал жуулчлалын салбарын сэргэлтэд тулд Засгийн газарын бодлогын дэмжлэг нэн шаардлагтай байна. Адал явдалт аялал жуулчлалын салбарт Засгийн газрын дэмжлэг болох зүйлс:**

- Дотоодын болон олон улсын хэмжээнд эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зорин очих газар, үйл ажиллагааны сурталчилгааг идэвхжүүлэх;
- Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд урамшуулал бий болгож, шууд дэмжлэг үзүүлэх;
- Салбарын эрэлтийг сэргээх зорилгоор татвар, төлбөр, хураамжийг бууруулах эсвэл бүрэн чөлөөлөх замаар дэмжлэг үзүүлэх.



# СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ГАРГАСАН ЗӨВЛӨГӨӨ




ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
USAID
FROM THE AMERICAN PEOPLE
World Health Organization
Representative Office for Mongolia
unicef
Коронавируст халдвар (COVID-19)-ын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй хүмүүс бодлоо эерэг болгох нь
Та зургийг хараад юу бодож байна?
Сөрөг бодол
Эерэг бодол
Бороо орж, хүчтэй салхи салхилах нь дээ
Үүлтэй ч гэсэн удахгүй нар гарах нь ээ, сайхан өдөр болох шинжтэй
Яанаа энэ хөлөг онгоц живчих вий дээ
Эрэг ойрхон харагдаж байгаа учир хүмүүс аюулаас аврагдах боломжтой
Модны навчис унаад, нэг л гунигтай байна шүү.
Намар болж налгар сайхан өдрүүд ирлээ.
Эерэг бодол нь аливаа асуудлыг зөвөөр тусгаж, стрессийг даван туулахад туслана гэдгийг санаарай.
Урам зоригтой
Аз жаргалтай
Хүчирхэг
Сэдэл тэмүүлэлтэй
ЭЕРЭГ БОДОЛ
зорилгод хүрэх, нөхцөл байдлыг шийдвэрлэхэд тусалдаг
Шийдэмгий
Санаачлагатай
Өөдрөг
Бүтээлч сэтгэлгээтэй
Эерэгээр сэтгэн бодож хандлагаа өөрчилье
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн мэдээлэл өгөх 24 цагийн утас 1800-2000


ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
USAID
FROM THE AMERICAN PEOPLE
World Health Organization
Representative Office for Mongolia
unicef
Коронавируст халдвар (COVID-19)-ын үед стрессийг эерэг, зөв аргаар даван туулъя!
Стрессийн үед сэтгэл хөдлөл тогтворгүй болж буруу шийдвэр гаргах эрсдэлтэй байдаг.
Баярлах
Бахархах
Сэтгэл ханах
Баяр хөөр
Инээд баясал гм
Уурлах
Бухимдах
Гуниглах
Уйтгарлах
Цөхрөх гм
Агаар салхинд гарах
Буу халах
Шүршүүрт орох
Стрессийг даван туулах эерэг аргууд
Сайтар унтаж амрах
Хөгжим сонсох
Өөрийгөө урамшуулах
Шинэ зүйл сурах
Хөгжим тоглох
Амьсгалын дасгал хийх
Бүжиглэх
Бясалгал, иог хийх
Ажлаа хуваарилах
Стресс тайлах зорилгоор архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх нь олон сөрөг үр дагаварт хүргэх тул үүнээс зайлсхийх хэрэгтэй.
Сэтгэцийн эрүүл мэндийн мэдээлэл өгөх 24 цагийн утас 1800-2000

# Коронавируст халдвар (COVID-19)-ын хариу арга хэмжээнд ажиллаж буй хүмүүст зориулсан урлагийн сэтгэл засал.

### Ач холбогдол

Стресс болон сэтгэл түгшилтийг бууруулна. Мөн бие махбодыг амрааж, тайвшруулна.

### Зурахдаа өөрийгөө сэргээх орчин бүрдүүлэх

Сайхан үнэртэй лаа асаах, биедээ эвтэй байдлаар суух, дуртай дуугаа сонсох гм..



## Урлагийн сэтгэл заслын зураас ашиглах арга

**Бэлдэх зүйлс:** Бал эсвэл үзэг, дурын хэмжээтэй бичгийн цаас.



Нэг цэгээс үүссэн салаалсан зураасуудыг зурна. Нарны цацраг, салют төсөөлөн зурж болно.

Үзгээ цааснаасаа салгалгүй дугуй зураасыг зурна.



**Сэтгэцийн эрүүл мэндийн мэдээлэл өгөх 24 цагийн утас 1800-2000**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

USAID FROM THE AMERICAN PEOPLE

World Health Organization Representative Office for Mongolia

unicef

## Коронавируст халдвар (COVID-19)-ын хариу арга хэмжээнд ажиллаж буй хүмүүс уур бухимдлаа зохицуулах нь

### Та хэр амархан уурладаг вэ?

- Машинтай явж байхад хэн нэгэн урдуур тань дайрах, саад болох...
- Хэн нэгэн таны юмыг зөвшөөрөлгүй авах, эсвэл алга болгох...
- Төлөвлөгдөөгүй яаралтай ажил гэнэт гарч ирэх...

### Та уурлахаараа ямар хариу үйлдэл үзүүлдэг вэ?

- Уурандаа ямар нэгэн юм эвдэж, хагалах зэрэг төрх үйл гаргаж магадгүй...
- Магадгүй нүүр чинь минчийтлээ улайж орилж, хашгирч болох юм...
- Дуугаа хураах эсвэл архи тамхи хэрэглэх...

